



УЛС ТӨР

ВЬЕТНАМ УЛСАД ЯМААНЫ МАХ НИЙЛҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦЖЭЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

ФРАНЦЧУУД “ДАЯАРЧЛАЛ”-ЫГ СОНГОЛОО

IV нүүрт

Дугаарын **60** мөр

Сайн дураар татвар төлөхийг хуульчилъя Б.ӨНӨРТӨГТӨХ

ҮЗЭЛ БОДОЛ

УТСААР ЭМЧИЛДЭГ БОЛТЛОО ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР “ТӨГС” ХӨГ ЖЖЭЭ

Б.ЭРХЭС

Татварын Ерөнхий газар өчигдөрөөс эхлэн “Татвар төлөгчдөд үйлчлэх танхим” байгуулжээ. Түүнчлэн, шилдэг татвар төлөгчийг шалгаруулж урамшуулах, татвар яагаад төлөх ёстойг сурталчилсан уралдаан тэмцээнийг ЕБС-ийн сурагчдын дунд зарласан аж. Татвар төлж буй иргэддээ талархах зорилготой энэхүү аяны хүрээнд олон ч уралдаан тэмцээн зохион байгуулагдах юм байна. Уг нь улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс татвараа төлөх нь сурталчилж, урамшуулахгүйгээр хэрэгжүүлэх ёстой бидний үүрэг. “Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмой” хэмээх Их Эзэн Чингис хааны сургааль бий. Ерөөс Их Монгол Улсын үеэс л иргэн бүхэн улсынхаа хөгжилд хувь нэмэр болох татвар, татаасыг төлсөөр ирсэн түүхтэй улс, бид. Амьдарч, ажиллаж, хөдөлмөрлөж байгаа бол олсон мөнгөнөөсөө татвар төлж, түүгээр нь улсаа хөгжүүлдэг олон улсын жишгээс бид ч гажих учиргүй юм.

Би оюутан ахуй цагтаа үрийн зулай үнэрлэсэн олон олон ээжүүдийн нэг. Залуу насны хэнэггүй зан, завгүй оюутны тарчигхан амьдралд хүлэгдсээр яваад төрөхийн хүндрэл гэгч нь болж байснаа нуугаад яахав. Хэдийгээр эмчийн хяналтад явсан ч өвдөж эхэлснээ мэдэхгүй шоконд орж, улмаар айлд сууж байхдаа ухаан алдаж орхисноо бүүр түүрхэн санадаг юм. Эмнэлгийн тусламж авч чадалгүй ухаан алдчихсан намайг тухайн үед Баянзүрх дүүргийн эмч нар дуудлагаар ирж үзсэн ч харьяаллын бус гэсэн шалтгаанаар айлд орхиод явсан байж билээ. Зөвхөн амь тариа хийгээд л Эх нялхас руу утасд гэсэн үүрэг өгөөд гарч одсон нь одоо ч санаанаас гардаггүй. Амнаас нь цагаан хөөс сахарсан, үхэл амьдралтай тэмцэж буй залуу ээжийг орхиод гарах хатуу сэтгэл тангараг өргөсөн эмч нарт байдаг гэхээр л

Үргэлжлэл нь III нүүрт



1 дүр зураг У. АРГУУЖИН

Р.ЖИГЖИД: ГАЗАР ТАРИАЛАН, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХОСОЛСОН ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛД НУТАГШУУЛЖ БАЙНА

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс

ПАСТА Гоймонгийн ТАЛААРХИ БАРИМТ

6

ДЭЛХИЙД НИЙТ 600 ГАРИУ Гоймонгийн ХЭЛБЭР БАЙДАГ

ПАСТА Гоймонг ХИЙДЭГ

ПАСТА ГЭХ ИТАЛИЙН ҮГ НЬ ЛАТИН ҮНЭЭС ГАРЛТАЙ БӨГӨӨД

ПАСТА ЗУУРСАН ГУРИЛ

ГЭСЭН УТГАТАЙ

НИЙТЛЭГ ПАСТА Гоймонгийн ХЭЛБЭРҮҮР

Fusilli

Penne Lisce

Lasagne

Tortiglioni

Spaghetti

Conchiglie Rigate

Bavette

ХАМГИЙН ИХ ХЭМЖЭЭГЭЭР ПАСТА Гоймонг ҮЙЛДВЭРЛЭДЭГ УЛСУУД

2.0 САГ ТОНН

3.3 САГ ТОНН

1.3 САГ ТОНН

25KG

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Улсын өмгөөлөгч нар хууль зүйн зөвлөгөө туслалцааг иргэдэд үнэ төлбөргүй өгнө



байгуулах чиг үүрэг бүхий Хууль зүйн туслалцааны төв 2014 онд байгуулагдсан юм.

Шүүхийн Ерөнхий зөвлөл, Хууль зүйн туслалцааны төв хамтран ажиллах санамж бичгийг өчигдөр үзэглэжээ. Санамж бичигт Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Т.Уранболор нар гарын үсэг зурсан юм. Хоёр тал хамтран ажилласнаар Хууль зүйн туслалцааны төв нь шүүхийн Тамгын газрын байранд иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл, туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх ажлын дадлага туршлагатай улсын өмгөөлөгчийг ажиллуулах нөхцөл боломж бүрдэж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш аливаа салбарын мэргэжлийн ажил үйлчилгээ чөлөөт өрсөлдөөнд суурилан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх болсны нэг жишээ нь өмгөөлөл, хууль зүйн үйлчилгээ юм. Энэ нь нэг талаас тухайн салбарыг хөгжүүлэх гол хүчин зүйл боловч нөгөө талаас хөрөнгө санхүүгийн боломжгүй, төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг авч чадахгүйд хүрэх, Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх зөрчигдөхөд хүрээд байв.

Ингэснээр хууль зүйн салбарт анх удаа “улсын өмгөөлөгч” гэх статустай өмгөөлөгчтэй болж төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч авах боломжгүй, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хамгаалж чадахгүй байгаа, эрх нь зөрчигдөх магадлал бүхий иргэдэд Үндсэн хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж, хууль шүүхийн өмнө тэгш байх бололцоог төрөөс бүрдүүлсэн билээ. Хууль зүйн туслалцааны төв нь хэдийгээр төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн яллагдагчид хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ч иргэний болон захиргааны эрх зүйн чиглэлээр хууль зүйн зөвлөгөө мэдээлэл авахаар иргэд тус төвд олноор ханддаг байна.

Ер нь дэлхийн жишгээр хууль зүйн туслалцааны байгууллагуудыг хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг чухал үүрэгтэй гэж үзэн ач холбогдол өгч ажилладаг бөгөөд манай улсын хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог цаашид илүү оновчтой, боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг холбогдох судалгаа, тоо баримтаас харж болох юм. Иймээс Хууль зүйн туслалцааны тухай хуульд шинэчилсэн найруулга оруулахаар төслийг боловсруулж эхлээд байгаа ажээ.

ХААН банк	Авах		Зарах		Хугалгаа хөгжлийн банк	Авах		Зарах	
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ
	2410.00	2615.00	21.29	3084.00	2407.00	2610.00	21.11	3085.00	
	2420.00	2678.00	21.56	40.70	2419.00	2675.00	21.66	40.49	
				348.00				43.46	
								347.50	
								350.40	

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

АЙЛЧЛАЛ

ВЬЕТНАМ УЛСАД ЯМААНЫ МАХ НИЙЛҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦЖЭЭ

Э.ТУУЛ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын урилгаар БНСВУ-ын Дэд ерөнхийлөгч Данг Тхи Нгок Тхинь манай улсад албан ёсны айлчлал хийхээр ням гарагт хүрэлцэн ирсэн билээ. Вьетнамын Дэд ерөнхийлөгчийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Ерөнхий сайдын Гадаад бодлогын зөвлөх Н.Чимгүүндарь, БНСВУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фан Данг Дыонг болон албаны бусад хүмүүс угтан авсан юм. Харин өчигдөр түүний албан ёсны айлчлал эхэлсэн бөгөөд Дэд ерөнхийлөгчийг Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат жанжин Д.Сүхбаатарын талбайд угтан авч, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүллээ. Мөн Дэд ерөнхийлөгч Данг Тхи Нгок Тхинь Төрийн ордонд морилон “Хүндэтгэл үзүүлэгч”-г гарын үсэг зурсан юм. Ёслолын дараа талууд хэлэлцээрт орсон юм. Дараа нь Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Вьетнам улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Энэхүү санамж бичиг нь салбарынхаа хамтын ажиллагааг зохицуулахад чиглэж байгаа бөгөөд Монгол Улсад үйлчилж байгаа баримт бичгүүд Вьетнамын баримт бичгүүд харилцан хүлээн зөвшөөрөгдөх аж. Түүнчлэн хоёр талдаа илгээж байгаа оюутнуудад үзүүлж буй нийгмийн халамж үйлчилгээний



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

асуудлыг ч харилцан тусгасан аж. Ийнхүү хэлэлцээр хийсний дараа хоёр тал ямар салбарт хамтран ажиллахаар тохиролцоонд хүрсэн талаар Ц.Мөнх-Оргил сайд мэдээлэл өгөв. Тэрбээр, “Хоёр улс нэгдүгээрт, цэрэг батлан, хамгаалах тусгай байгууллагууд буюу хүчний байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэ

гэлээ. Монгол Улс Зүүн өмнөд Азидаа Вьетнамыг түшиц улсаа болгож, хөгжүүлэх сонирхолтой байна. Вьетнам улсын хувьд энэ жил АПЕК-ийг даргалж байгаа. Монгол Улс АПЕК-тай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн тулд Вьетнамыг тусалж, дэмжиж ажиллаач гэдэг хүсэлт тавьж байна. Хоёр дахь гол асуудал бол худалдаа, эдийн

засгийн хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх. Вьетнамтай хийж байгаа Монгол Улсын худалдаа маш бага буюу жилдээ 45 сая доллар байна. Гэтэл бололцоо маш их байна. Вьетнамын талаас ч Монголын талаас ч худалдаагаа нэмэгдүүлэх сонирхол их байдаг. Тийм учраас онгөрсөн дөрөвдүгээр сард хоёр улсын хооронд нэг чухал гэрээнд

гарын үсэг зурсан. Мал эмнэлэг, ургамал хорио цэрийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Ингэснээр Монголын мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүнийг үндэс тавигдсан. Вьетнам улс Монгол Улсаас ямааны мах импортлох сонирхолтой байдаг юм байна, халуун орон учраас.

Ажил ч эхэлсэн. Монголын 4-5 махны үйлдвэрийг Вьетнамын тал Засгийн газрын төвшиндөө хүлээн зөвшөөрч, эхний ажилт хийгдсэн байна. Энэ бол туршилтын ажилтнууд. Энэ жил 20 тонн ямааны мах экспортлох зорилт тавьсан байна. Вьетнам жилдээ 200 тонноос ч илүү ямааны мах, ноолууран бүтээгдэхүүн ч илүү импортлох гэдэг сонирхлоо илэрхийлж байна. Зөрүүлээд бид Вьетнамаас бэлэн бүтээгдэхүүн түүн дотроо радио электрон, далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн авах бололцоотой. Далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн нь гүн хөлдөөсөн. Бид эндээс гүн хөлдөөсөн махан бүтээгдэхүүнээ экспортлоно.

Түүнчлэн Монгол Улс аялал жуулчлал, оюутан солилцоонд ихээхэн анхаарал хандуулж байна. Өнөөдрийн байдлаар Монголын 60 гаруй оюутан Вьетнамд сурашдаг, Вьетнамаас Монголд 30 гаруй оюутан сурашдаг байна. Хоёр талдаа тэтгэлэг олгодог. Хэлэлцээрийн үеэр сая оюутны тоог нэмэгдүүлэхгүй, тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэе, салбаруудаа илүү анхаарья гэдэг тохиролцоонд хүрлээ. Хөдөө аж ахуйн салбар дээр онцгой анхаарч хамтын ажиллагаагаа хөгжүүлэе гэсэн тохиролцоонд хүрсэн” хэмээлээ. Дэд Ерөнхийлөгч хэлэлцээний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ-ын даргад бараалхаж хоёр улсын хамтын ажиллагааны талаар санал солилцсон юм.

MINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:

С.ГАНТГОГО

Орлогч эрхлэгч

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:

Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба

Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:

Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:

Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:

Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба:

Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:

М.ДАВААДУЛАМ
99042510Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн

Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.



ХААЛТТАЙ ХУРАЛДААНААС

Хүний эрхийг ноцтой зөрчсөн заалт олон байна гэв

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр хуралдаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцжээ. Гэхдээ бүлгийн хурлын талаар мэдээлэл хийсэнгүй. Тус хуулийн төслийг УИХ-ын өнгөрсөн долоо хоногийн нэгдсэн чуулганаар хэлэлцэх үед УИХ дахь Ардчилсан намын бүлэг завсарлага авсан билээ.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хүний эрхийг дордуулсан хэд хэдэн заалт байгаа учраас ажлын хэсэг эргэж харах шаардлагатай гэж бүлгийн гишүүд үзсэн аж. Тухайлбал, Засгийн газраас анх өргөн барьсан хуулийн төсөлд

цагдан хорих байранд гүйцэтгэх ажиллагаа явуулахыг тодорхой хэрэгт хориглосон байтал ажлын хэсэг цагдан хорих байранд гүйцэтгэх ажиллагаа явуулах хэргийн зүйлчлэлийг өргөтгөсөн. Мөрдөн шалгах нууц ажиллагаа болон прокурорын зөвшөөрөлтэй явагдсан гүйцэтгэх ажлын үр дүн болох баримт мэдээллийн талаар мөрдөгч магадлагаа үйлдэж, прокурор баталгаажуулж хавтаст хэрэгт тусгана гэж өөрчлөх саналыг ажлын хэсэгт гаргаж дэмжигджээ. Энэ нь иргэнд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэх ажиллагаа явуулж болох боломжийг нээж өгсөн ба гүйцэтгэх ажиллагаагаар олж

авсан мэдээллээ шүүх хурлын нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэх боломжтой болгож буйг хүний эрхийг ноцтой зөрчиж байна хэмээн үзэж байгаа юм. Түүнчлэн сэжигтэн шүүхийн зөвшөөрөлтэйгээр баривчлах хугацааг 24 цагаас хэтэрч болохгүй байхаар Засгийн газраас анх өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгасан боловч 48 цаг болгон өөрчлөх саналыг байнгын хороо дэмжсэнийг эргэн харах шаардлагатай учраас ажлын хэсэгт эдгээр болон хүний эрхийг ноцтой зөрчиж буй бусад заалтуудыг өөрчлөх тухай санал оруулах нь зүйтэй хэмээн УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд үзжээ.

Зөвлөлдөх санал асуулгаар мэдээлэл сонсчээ

УИХ дахь МАН-ын бүлэг өчигдөр ээлжит хуралдаанаа хийж, Зөвлөлдөх санал асуулгын талаархи мэдээллийг сонссон байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттайгаар зохион байгуулж, ерөнхий дүнг өнгөргөж долоо хоногийн баасан гарагт УИХ-ын даргад танилцуулсан билээ. Зөвлөлдөх санал асуулга Засгийн газрын бүтэц, Ерөнхийлөгчийн томилгодог хугацаа болон эрх үүргийн хүрээ, парламентын тогтолцоо, засаг захиргааны

нэгжийн хуваарилалт, төрийн албаны тогтолцоо, томилгоо гэсэн үндсэн зургаан чиглэлд түүврийн аргаар санал асуулга явагдсан. Санал асуулгаар хоёр парламентын тогтолцоонд шилжих, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх гэсэн хоёр саналыг санал асуулгад оролцогсод дэмжээгүй юм. Эрх баригч намын бүлэг өчигдөр уг мэдээллийг сонсч, дотооддоо санал солилцсон байна. Гэвч бүлгийн хуралдааны асуудлаар мэдээлэл хийсэнгүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

PHOTO NEWS

Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг бүртгэх эсэхээ 14-ний дотор шийднэ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх зургадугаар сарын 26-нд болно. Өнгөрсөн долоо хоногт намууд хуулийн хугацаандаа багтан нэр дэвшигчээ тодруулж, баталгаажууллаа. МАН-аас тус намын дарга М.Энхболд, АН-аас УИХ-ын гишүүн асан Х.Баттулга, МАХН-аас намын дарга Н.Энхбаяр нар дэвшинхээр болсон. Тэгвэл хуулийн дагуу намууд нэр дэвшигчдээ энэ долоо хоногт буюу пүрэв гарагаас өмнө СЕХ-нд бүртгүүлэх ёстой. Хуульд зааснаар нэр дэвшүүлэх хугацаа дууссанаас хойш тав хоногийн дотор буюу ирэх тавдугаар сарын 11-ний дотор нэр дэвшигчдийн баримт бичгийг сонгуулийн төв байранд ирүүлэх учиртай билээ. Харин сонгуулийн төв байгууллага нэр дэвшигчдийн талаарх баримт бичгийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор буюу тавдугаар сарын 14-ний дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргах юм. Мөн сонгуулийн төв байгууллага нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гарсанаас хойш ажлын гурав хоногийн дотор буюу тавдугаар сарын 17-ны дотор Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг улсын хэмжээнд олон нийтэд мэдээлэх учиртай. Дашрамд дурьдахад, сонгуулийн сурталчилгаа зургадугаар сарын 6-25-ыг дуустал үргэлжилнэ.



МАХН бага чуулганаараа Ерөнхийлөгчийн сонгуульд намын дарга Н.Энхбаярыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн. Шийдвэр гаргасан өдрөө МАХН-ынхан Тусгаар тогтнолын талбайд цуглаан зохион байгуулж, СЕХ-д шаардлага хүргүүлсэн бол өчигдөр Тусгаар тогтнолын ордны өмнө суултаа үргэлжлүүлсэн юм. УИХ-ын гишүүн асан З.Баянсэлэнг тэргүүтэй МАХН-ын гишүүд, дэлжигчид эрх баригчдыг хуулийн байгууллагад нэвээлж, Н.Энхбаярыг сонгуульд өрсөлдөх эрхийг хааж байна хэмээн үзэж байгаагаа илэрхийлээ.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Сайн дураар татвар төлөхийг хуульчилъя

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Харамсалтай нь энэ үүргээ биелүүлдэг хүн манайд тун цөөхөн юм. Тиймээс ч сурталчилж, уриалаад ч болов татвар авах гэж сарын аян хүртэл зарлаж буй тэднийг буруутгах аргагүй юм. Татварын Ерөнхий газрын албан тушаалтны өгч буй мэдээллээс үзвэл, Монгол Улсын нэг сая орчим иргэн “суутган” татвар буюу цалин, олсон орлогоосоо татвар төлдөг аж. Мөн 100 орчим мянган аж ахуйн нэгж олсон орлогоосоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг гэсэн тоон мэдээ байна. Манайх гурван сая гаруй хүн амтай. Үүнээс татвар төлдөггүй насанд хүрээгүй иргэн нэг сая орчим гэж үзвэл үлдсэн хоёр сая гаруй нь татвараа зайлшгүй төлөх ёстой. Гэтэл дээрх тоон мэдээллээс харахад дөнгөж нэг сая орчим иргэд л үүргээ ухамсарладаг аж. Тэд ажил хийдэг учраас цалингаасаа татвараа төлдөг хэрэг л дээ.

Харин үлдсэн хэсэг нь яагаад татвар төлөхгүй байна вэ. Тэд эрүүл мэндийн даатгалаа төлдөггүй атлаа тэд эмнэлгийн үйлчилгээ авдаг. Хотын хөгжилд хувь нэмрээ оруулаагүй атлаа машин унаж байгаа. Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөө халааснаасаа 100 төгрөг ч гаргаж үзээгүй мөртлөө татвар төлөгч миний мөнгөөр хэмээн “дөвчигнөө” ч мартахагүй юм. Онцолж дурьдвал, татвар төлдөг эсэх нь тодорхой бус хүмүүсийн тэргүүн эгнээнд сүм дуган хийдэг шавилж буй лам нар ордог. Цаашлаад дуучид, томоохон зах худалдааны төвд лангуу түрээсэлж буй иргэд байна. Мөн бичил уурхай эрхлэгчид буюу гар аргаар алт олборлож буй иргэд ч татвар төлөхгүй нь олонтай аж. Бичил бизнес эрхлэгч, хувирараа хөдөлмөр эрхлэгч гэх мэтээр татвар төлөхөөс зайлсхийдэг, татвар төлөх нь ямар ач холбогдолтойг мэдэхгүй иргэд хэтэрхий олон байгаа. Эдгээр иргэдээс татвар яагаад авдаггүйг тодруулахад “Авах ёстой гэсэн эрхгүйн орчин байхгүй” гэсэн хариулт өгч байх юм. Өөрөөр хэлбэл, төрийн болон хувийн хэвшилд ажиллаж цалин авдаггүй л бол та татвараа өг, эс бөгөөс эмнэлгийн үйлчилгээ авахгүй, цалингийн зээл өгөхгүй гэсэн хуульчилж байхгүй гэсэн үг. Уг нь гутал тосолдог ч байсан та татвараа сайн дураар төлөх ёстой гэсэн хууль өмнө нь хэрэгждэг гэсэн хууль билээ. Та олсон орлогоосоо улсынхаа хөгжилд 200 төгрөг ч болов өгөх ёстой. Энэ таны үүрэг шүү гэсэн сайн дурын татварын хууль хэрэгжихээ больсноос хойш татварыг ял мэт хүлээж авдаг, татвараас булгдаг зугтдаг хэсэг бүлэг хэтэрхий олон болжээ. Аргаа барахдаа татвар төлөгчид үйлчлэх танхим байгуулж, үүргээ биелүүлдснийх нь төлөө шагнаж урамшуулж суна. Уг нь татвар төлөх нь таны үүрэг гэдгийг цэцэрлэгт байхаас нь л суулгаж өгдөг олон улсын жишиг байдаг. Гэтэл манайд эсрэгээрээ.

Хэвлэл мэдээлэл хүртэл татвар нэмэгдэх ял юм шиг, татвар авах нь буруу гэх мэтээр дандаа буруу ойлголт өгдөгөөс биднийг шулж, дээрэмдэж байгаа төрийн боловсон дээрэм гэсэн ойлголт хүүхдийн тархинд суудаг аж. Татвар төлөх нь таны үүрэг, төрөөс хариуцлага нэхэхийн тулд эхлээд үүргээ биелүүлэх ёстой шүү гэдгийг хүүхдийн тархинд багаас нь суулгаж өгөх ёстой юм байна. Нөгөө талаар гар аргаар алт олборлож буй иргэд ч татвараа асуудалгүй төлж гэмээнэ төрийн үйлчилгээ таньд ижил тэгш хүрнэ гэдгийг ойлгох учиртай юм. Бидний татварын мөнгөөр эрүүл мэндийн салбарыг хөгжүүлдэг. Цаашлаад замын ажилд хөрөнгө оруулалт хийгддэг. Гэтэл татвар төлөхгүй атлаа эрүүл мэндийн салбар дампуурсныг шүүмжилж, зам эвдэрэнд төрийг буруутгах хэрэг байна уу, татвар төлөгчид минь. Ер нь сайн дурын татварын хуулийг дахин баталж, хэрэгжүүлсэн ч яах вэ дээ. Үүргээ биелүүлэхгүй бол хуулиар далайлгахад буруудах юун. Бид дуучдын тоглолтыг мөнгө төлж үздэг. Бас ном уншуулахдаа ч тарифаар мөнгөө төлдөг. Захаас бараа худалдаж авахдаа ч мөнгө төлж байна. Улсынхаа баялгийг ухаж мөнгө олж байгаа бол орлогоосоо 100 төгрөг ч болтугай улсдаа өгөхөд буруу юу байх билээ.

УТСААР ЭМЧИЛДЭГ БОЛТЛОО ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР “ТӨГС” ХӨГЖЖЭЭ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Цаашлаад эмнэлгээс эмнэлэг рүү дамжиж явахдаа хэчнээн хүний өвчин хүндэрч, улмаар амиа алдаж буйг яг таг тоон баримтаар хэлэх боломж алга. Энэ тухай гомдол санал байсхийгээд л гардаг ч хуультай учраас хуулиар дагаж мөрдсөн гэдэг хариулт өгөөд амыг нь тагладаг юм билээ. Саяхан, нэгэн дуучин залуу нас барсан гунигтай мэдээ дуулав. Гэтэл “харьяаллын бус” гэсэн шалтгаанаар өөр эмнэлэгт шилжүүлэх гэж цаг алдсанаас болж нас барсан гэсэн мэдээллийг албан бус эх сурвалж өгсөн юм. Хэрвээ энэ үнэн бол хуультай байхаас үл хамааран хариуцлага тооцох учиртай баймаар. Эмч хүний үүрэг бол бусдын амь насыг аврах. Эмнэлгийн тусламж үйлчилгээг яаралтай үзүүлэх. Гэтэл тангараг өргөсөн эмч нар манай харьяа биш бол үхсэн ч надад хамаагүй гэдэг сэтгэлээр хандсаар байгааг хэзээ цэгцлэх вэ, А.Цогцэцэг сайд аа. Монголын эрүүл мэндийн салбарт хамгийн сайн хэрэгжиж буй энэ зүйл заалтыг эргэн харж, нягтлах цаг нь болсон баймаар. Хүний өвчин хэлж ирдэггүй. Баянгол дүүрэгтээ очиж өвдөнө өө гэж хүлээдэггүй байлтай. Гэнэтийн осол аваар, зодуурын бэртэл, төрөхийн хүндрэл, хордлого, даралт харвах гэх мэтээр аминд халтай өвчин зовлон бишгүй олон. Гэтэл Баянзүрх дүүрэгт ухаан алдсан таны буруу. Баянгол руугаа ачигдаад яв гэж хэлдэг хатуу сэтгэл тэдэнд байгаа учраас л маш олон иргэн харьяалал гэх хатуу зүйл заалтаас болж хорвоог орхиж, эс бөгөөс өвчин нь хүндэрч байгааг нуугаад яахав. Баянзүрх дүүрэгт ухаан алдсан, даралт харвасан бол тухайн дүүргийн эмч, эмнэлгийн ажилтнууд эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэхэд буруудах зүйл юу ч байхгүй. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, улмаар хэвтэн эмчлүүлэх, эсвэл эмчилгээний явцад

харьяа дүүрэгт нь гараас гарт гэсэн зарчмаар шилжүүлэх боломж хангалттай байгаа. Үгүй ядахдаа л дүүргийн эмч, сувилагч ирэх хүртэл тусламж үйлчилгээг бүрэн үзүүлж, гараас гарт шилжүүлдэг болохсон. Эс бөгөөс харьяа дүүрэг хамаарахгүйгээр эмнэлгийн тусламж авах өвчний нэр, жагсаалтыг баталж яагаад болохгүй гэж. Хүүхэд, хөгшиддөө ч боловхарьяа дүүрэгт гэсэн хатуу зүйл заалтаа цуцалж болохгүй гэж үү, сайд аа. Үхэл амьдралтай тэмцэж буй хүн бүхэн өөрт хамгийн ойрхон эрүүл мэндийн салбарт л ханддаг. Хажуухад эмнэлэг байвал бурханы аврал хэмээн баярлаад гүйх тохиолдол бидний амьдралд бишгүй олон тохиолддог. Гэтэл та манай харьяа биш байна. Харьяа дүүрэгтээ хандана уу гэсэн хариулт авч, улмаар амиа алдана гэдэг дэндүү харамсалтай. Зөвхөн “харьяалал” гэсэн шалтгаанаар л хүүхдээ, ээжийгээ, аавыгаа алдана гэдэг эрүүл мэндийн салбарын хамгийн том эмгэнэл биш гэж үү.

Гялтайх сайн мэдээ, гийгүүлэх амжилт алга

Энэ мэтээр эрүүл мэндийн салбар буруу утгаараа хөгжөөд байна. Түргэн тусламж үзүүлэх гэдгийг утсаар зөвлөгөө өгөх гэж ойлгоод удлаа. Утасны цаанаас эмчилдэг болтлоо монголын эрүүл мэндийн салбар “төгсөрчихөж”. Мэдээж наад захын зөвлөгөө, анхан шатны тусламжийг утсаар зөвлөж болох ч үхэл амьдралтай тэмцэж буй өвчтөнд тийм эм өг, тэгж тариа хий гэсэн зөвлөгөөг утсаар өгч арай л боломгүй байлтай. 39 хүртэл халуурч буй нярай үрсдээ эмчийн зөвлөгөөг утсаар өгч, эмийн зөвлөгөөг хайхрамжгүй өгдөг болтлоо ачааллаа даахгүйд хүрсэн гэдэгт итгэхгүй нь. Утсаар хэлж өгсөн эм нь харшилж, реакци өгвөл хэрхэх вэ. Туршлагагүй залуу

эж тунг нь буруу өгвөл яах билээ. Хатуухан хэлэхэд, өвчтөн амьсгал хураагчид хойно л түргэн тусламж очдог гэхэд хэтийдэхгүй. Яаралтай дуудлага аваад, очлоо гэхэд өөрийгөө танилцуулдаг, эмчийн зөвлөгөөг бүрэн өгдөг, ямар эм бичиж өгснөө тайлбарладаг дуудлагын эмч тун цөөхөн байна. Бараг л зүгээр байхад хүн дуудлаа хэмээн тас ширвээд гарч одох нь элбэг. Олон улсад түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлэхдээ ямар албан тушаалтай, хэн гэж эмч болохоо хэлж, хэрхэн бие асарч сувилах талаар нэгбүрчлэн танилцуулж, эмийн үйлчилгээг ч нарийн тайлбарладаг. Түргэн тусламж дуудах шаардлагагүй өвчтөн байсан ч очсон бол ажлаа хийгээд л гарах нь эмч хүний үүрэг, өргөсөн тангараг. Гэтэл Монголын эрүүл мэндийн салбарт энэ байдал огтхон ч хэрэгжихгүй юм. Утсаар зөвлөгөө өгдөг,

эмчилгээ бичиж, онош тавьдаг, дуудлагаар очсон бол загнаж зандрал гардаг, харьяа дүүргээ дууд хэмээн хажь оддог гажиг тогтолцоо хэдийнэ амь бөхтэй оршоор байна. Энэ талаар өөрчлөлт хийх цаг ч болчихож. Нөгөө талаар түргэн тусламж авч буй иргэд ч хэн гэж эмчээс хэрхэн зөвлөгөө авсан, ямар найрлагатай эм бичүүлж авснаа нэгбүрчлэн тэмдэглэж авах хэрэгтэй байгаа юм. Дараа ямар нэг асуудал боллоо гэхэд буух эзэн буцах хаягтай үлдэх ёстой учраас эмчилсэн, эмчлүүлсэн хоёр хоёулаа хариуцлагатай байх хэрэгтэй билээ. Энэ мэтээр эрүүл мэндийн салбарт гялтайх мэдээ, гийгүүлэх амжилт огтхон ч гарахгүй дахиад л нэг жилийг үлдээ. Салбарын сайд нь мянга түм солигдож, сайхан сайхан амьдрал өгдөг ч өөрчлөлт хийгдсэнгүй. Улам л хүнд сурталд идэгдэж, мөнгөгүй бол үх хэмээн ард

түмнээ басамжилсаар суугаа. “Элэг бүтэн Монгол” хэмээн зурагт радиогоор өдөр шөнөгүй сурталчлах атлаа эрүүл мэндийн салбар өдрөөс өдөрт авлига хүнд сурталд идэгдсээр. Хагалгаа хийж байгаагаа “төлбөртэй халтуур” гэж ойлгодог болчихож, эмч нар. Техник тоног төхөөрөмжийг тэрбум, тэрбумаар шинэчилж, эмнэлгийн машиныг шинэчлэх нь эрүүл мэндийн салбарын шинэчлэл биш ээ, сайд аа. Энэ салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтнуудын сэтгэлгээ, сэтгэхүй, хүнд суртлыг л өөрчилж, хүний төлөө ажилладаг нинжин сэтгэлтэй эмч нар бэлтгэсэн цагт л сая л жинхэнэ шинэчлэл, өөрчлөлт болох учиртай юм. Цаасан дээр хөтөлбөр баталчихаад шуудах, тэр нь хөрсөн дээрээ хэрэгжиж чадаж байгаа эсэхийн хооронд алд дэлэм зөрүү бий шүү.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“
 Өй а даүааеүа
 ааүеаа аүае
 ıçүö ñýðäүöıéá
 íèéäүì ä
 àèé áîëäî õ
 øààðäèèàààòàé
 ”

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Д.Оосухорал

ДЭЛХИЙ

Францчууд “ДАЯАРЧЛАЛ”-ЫГ СОНГОЛОО



Эммануэль Макрон гэж хэн бэ

Тэрбээр Францын зүүн хойд Амьен хотын уугуул. Түүний эцэг, эх нь хоёулаа эмч нар байжээ. Харин эхнэр Брижит нь түүний ахлах сургуулийн багш байв. Тэд танилцах үед эхнэр нь гэрлэсэн гурван ч хүүхэдтэй 40 сүргэж яваа эмэгтэй байсан бол Францын шинэхэн төрийн тэргүүн ердөө 15 настай байсан гэдэг. Чухам тэр үед л багшдаа сэтгэл алдарчээ. Гурван жилийн өмнө Э.Макроныг хэн ч мэддэггүй байв.

Философи, уран зохиол, сонгодог хөгжимд хайртай Макрон “хэт зүүний бус, хэт барууны бус” төвийн үзэл баримтлалт “En Marche” хөдөлгөөнөө нэг жилийн өмнө л байгуулж байсан гэдэг. Түүнчлэн, Франсуа Олландын Засгийн газарт Эдийн засгийн сайдаар ажилласан маш товчхон намтартай. Тиймдээ ч, нас, туршлагыг нь ч бодсон ийм хүн Францыг тэргүүлэх боломжгүй гэж үзэх хүмүүс ч олон байлаа. Гэхдээ түүнийг өмнөх үеийн аугаа удирдагчидтай адилтгах нэгэн ч цөөнгүй байв.

Наполеон Бонапарт гэхэд 1804 онд Францын эзэн хаанаар өөрийгөө өргөмжилж байх тухайн үедээ Э.Макроноос нэг насаар л ах байжээ.

Макрон оюутан байхаасаа ажлын гараагаа эхэлжээ. Эхэндээ Францын алдартай философичийн туслахаар ажилладаг байсан гэдэг. Улмаар сургуулиа төгссөний-хөө дараа Францын Сангийн яаманд ажилд оржээ. Тэндээ хэсэгтээ ажилласны дараа “Ротшильд”-ын салбар хөрөнгө оруулалтын банкинд ажилд орж, хэд хэдэн компанитай нэгтгэсэнээр сая эвро олж чадсан байна.

Ялалтын баярын мэнд хүргэе

Орос улс өнөөдөр Аугаа их Эх орны ялалтын баярын өдрийг тэмдэглэнэ. Одоогоос 72 жилийн тэртээх 1945 оны тавдугаар сарын 9-ний энэ өдөр Дэлхийн II дайныг өдөөгч Гитлерийн Герман Берлин хотод уг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зурснаар энэ өдрийг албан ёсоор Зөвлөлтийн ард түмний ялалтын баяр болгон тэмдэглэх болсон юм. Энэ өдөр бол ганц зөвлөлт ч гэлтгүй Дэлхийн II дайнд зовж, зүдэрсэн бүхий л ард түмний ялалтын баяр билээ. Дэлхийн II дайны хөлд нийт 60 гаруй улс их бага хэмжээгээр нэрвэгдэж, түүнд 70-аад сая хүний алтан амь үрэгдсэн байдаг. Эх орны дайнд тэр үеийн ЗХУ хамгийн их хохирол амсаж, 27 сая хүний алтан амь үрэгдэж, том жижиг 1710 хот, 70 мянга гаруй тосгон суурин бүрэн болон хагас нуранги болж, 32 мянга орчим үйлдвэр аж ахуйн газар, 98 мянган сангийн аж ахуй, 1876 хамтрал шатаж, нурж сүйдсэн гэдэг тоо бий. Хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн их хохирол дагуулсан энэ дайнд амь үрэгдсэн гурван хүн тутмын хоёр нь эгэл жирийн ард иргэд, хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд байсан гэдэг. Түүхэн тэмдэглэлт энэ өдрийг манай хөрш Орос орон даяар сүүр жавхлантай тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд өнөөдөр Москва хотын Улаан талбайд ёслолын сүрт жагсаал эхэлнэ. Энэ удаагийн жагсаалд нийтдээ 10 мянган цэрэг, 114 хуягт техник Улаан талбайг дамжин өнгөрөх бол тэнгэрт хэдэн арван нислэг тэрэг, байлдааны онгоднууд зөрөлдөн нисэх гэнэ.

БНСУ-ын дараагийн Ерөнхийлөгч өнөөдөр тодорно

Авлига болон эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан гэх дуулиан шуугиантай холбоотойгоор Ерөнхийлөгч Пак Гын Хэг албан тушаалаа нь огцруулсан өмнөд солонгосчууд өнөөдөр дараагийн ерөнхийлөгчөө сонгох гэж байна. Хамгийн сүүлд явуулсан санал асуулгын дүнгээс үзвэл, тус улсын хамгийн том сөрөг хүчин бодон Ардчилсан намаас нэр дэвшигч Мун Жэ Ин дэмжигчдийнхээ тоогоор тэргүүлж байна. Энэ сарын эхний долоо хоногт явуулсан санал асуулгад оролцогчдын 40 хувь нь Мунгийн дэмжиж байгаагаа илэрхийлжээ. Харин төвч үзэл баримтлалтай Ардын намаас нэр дэвшигч Ан Чоль Суг дэмжигчдийн тоо 20 хувьтай байна. Аныг дэмжигчдийн тоо дөрөвдүгээр сарын эхний хоёр долоо хоногийн хугацаанд Мунийхтэй ойртож очсон хэдий ч аюулгүй байдлын асуудлаар баримтлах байр суурь нь тодорхойгүй, телевизээр явуулсан мэтгэлцээний үеэр Мун рүү хэтэрхий дайрч довтолж байсан зэрэг нь дэмжигчдийнх нь тоо буурахад нөлөөлжээ.

Италийг зорьсон 80 орчим дүрвэгч замдаа амиа алджээ

Ливи улсаас Итали руу хүрэхээр явж байсан 80 орчим дүрвэгч замдаа буюу Газар Дундын тэнгист живж амиа алдсан тухай АНСА агентлаг мэдээлжээ. Амьд гарсан 40 хүнийг эргийн хамгаалалтын хөлөг онгоцны багийнхан аварч, Рагуза хотын Позало боомтод хүргэсэн байна. Хэдэн хоногийн өмнө Ливнээс хөдөлсөн уг усан онгоц даац хэтрүүлсний улмаас осолджээ. Рагуза хотын прокурор ослын хэргийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн байна. Олон улсын цагаачлалын асуудал эрхэлсэн байгууллагын /IOM/ мэдээлснээр, он гарснаас хойш гуравдугаар сарын 19-нийг хүртэлх хугацаанд 20484 дүрвэгч далай тэнгисийг гатлан Европт ирснээс 80 гаруй хувь нь Италид, бусад нь Испани, Грект үлджээ. Энэ тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа юм. Тодруулбал, 2016 он гарснаас хойших 79 хоногт 160331 хүн Европт ирж байжээ. Харин амиа алдсан дүрвэгчдийн тоо энэ он гарснаас хойш 525-д хүрсэн нь, 2016 оны мөн үеийнхтэй харьцуулахад 553 хүнээр цөөн байгаа юм.



Б.ДАВААХҮҮ

Францын сонгуулийн насны иргэд “даяарчлал”-ын бодлого дэвшүүлсэн Эммануэль Макрон, “Дангаарчлал”-ыг санал болгосон “Үндэсний фронт” намын нэр дэвшигч Марин Ле Пен нарын хэнийг нь дараагийн Ерөнхийлөгч болгохоо өнгөрөгч ням гарагт шийдлээ. Эсрэг тэсрэг улс төрийн бодлогыг дэвшүүлсэн хоёр эрхэм өнгөрсөн сард явагдсан эхний шатны сонгуульд тунаан үлдсэн байдаг.

Харин шийдвэрлэх шатны сонгууль өнгөрөгч ням гарагт болж, 39 настай Э.Макрон Францын өнөөгийн тэргүүн Франсуа Олландыг залгамжлахаар боллоо.

Улс төрд ердөө гурван жилийн өмнө орж, 12 сарын өмнөхөн “En Marche” гэх улс төрийн намаа байгуулсан Э.Макрон хэт баруун, эсвэл хэт зүүний улс төрийн хүчинд харьяалагддаггүй анхны Ерөнхийлөгч. Түүнчлэн, Францын улс төрийн түүхэн дэх хамгийн залуу Ерөнхийлөгчөөр нэрлэгдээд байна. Тэрбээр 65.5 хувийн саналаар тэргүүлсэн бол түүний өрсөлдөгч “Үндэсний фронт” намын дарга Марин Ле Пен 34.5 хувийн санал авсан байна. Сонгуулийн дүн нэгэнт гарсны дараа Э.Макроны мянга мянган дэмжигчид Парис хотын төв талбай Луврын музейн өмнө цугларч, шинэ Ерөнхийлөгчдөө баяр хүргэжээ. Харин ялалтын мэдэгдлээ хийхдээ шинэхэн Ерөнхийлөгч “Өнөө шөнө та бүхэн яллаа.

Франц яллаа. Хүн бүр л бидэнд үүнийг боломжгүй гэж хэлж байсан. Гэхдээ тэд францыг мэдэхгүй. Бидэнд хүч чадал, хүсэл тэмүүлэл байна. Харин айдаас алга. Франц түүхэндээ дахин шинэ хуудас нээлээ” хэмээжээ.

Марин Ле Пен энэ удаагийн сонгуулийг Э.Макроны дэвшүүлж буй гадаад худалдааны бодлого, цагаачлал, “даяарчлал” болон Франц улсын хил хязгаар, үндэсний онцлогийг хамгаалах “дангааршил” хоорондын тулаан гэж тодорхойлсон байдаг. Энэ нь ч учиртай.

Марин Ле Пен Ерөнхийлөгч болсон тохиолдолд Францын гишүүнчлэлийг өөрчлөх талаар ЕХ-ны гишүүн орнуудтай нэн даруй хэлэлцэнэ гэдгээ илэрхийлж байсан бол Макрон хөрш зэргэлдээ орнуудтайгаа нягт харилцаатай байх ёстой гэх зарчмыг баримталдаг юм. Түүнээс гадна “Үндэсний фронт” намын дарга цагаачдын урсгалыг хязгаарлах, албадан гаргахаа амласан бол Эммануэль Макрон Ерөнхийлөгчөөр сонгогдвол ажлаа авсан эхний зургаан сардаа багтааж, орогнол хүссэн цагаачдыг хүлээн авахаа амлаж, Францыг цагаач, дүрвэгчдийг халуун дотноор хүлээн авдаг улс болгохоо илэрхийлж байсан билээ. Ийнхүү эсрэг тэсрэг “даяарчлал” болон “дангаарчлал” гэсэн хоёр харилттай сонголтоос францчууд Э.Макроныг сонголоо.

ЭМГЭНЭЛ



ЦЭДЭНДАМБЫН НАЦАГДОРЖ (1944-2017)

Монгол Улсын гавьяат тамирчин Цэдэндамбын Нацагдорж 2017 оны тавдугаар сарын 03-ны өдөр өвчний улмаас таалал төгсч, бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо. Ц.Нацагдорж нь 1944 онд Баянхонгор аймгийн Баянлиг суманд төрсөн. 1953-1960 онд дунд сургууль, 1965-1968 онд цэргийн алба хаасан, 1965-1976 онд улсын шигшээ багт тамирчин, 1973-1977 онд УБДС-ийн Биесийн тамирын ангийг багш, дасгалжуулагч мэргэжлээр төгссөн.

Тэрээр 1965 оноос эхлэн чөлөөт бөхөөр хичээллэж, 1965-1976 онд Улсын шигшээ багт тамирчин, 1976-1991 онд Цагдаагийн “Хүч” БТС-ын нийгэмлэгт үндэсний бөх, чөлөөт бөхийн багийн ахлах дасгалжуулагч, 1993-1994 онд Улсын шигшээ багийн ахлах дасгалжуулагч, 1994-2000 онд Эрдэнэтийн “Хангарьд” спорт клубт бөхийн чөлөөт барилдааны ахлах дасгалжуулагч, 1991-1993, 2000-2003, 2006-2007 онуудад БНХАУ-д чөлөөт бөхийн мэргэжилтэн дасгалжуулагчаар, 2002-2006 онд АНУ-ын Калифорн мужийн Оакланд хотын 111 дүгээр сургуульд гэрээт дасгалжуулагчаар, 2008 оноос Нийслэлийн Биесийн тамир, спорт хороонд Оюутны шигшээ багийн ахлах дасгалжуулагчаар ажиллаж байв.

Ц.Нацагдорж нь улсын шигшээ багт тамирчин байх хугацаандаа Олимпын их наадамд гурав, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд зургаа, тивийн аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа тус тус оролцож давардсан тоогоор зургаан удаа шагналт байранд шалгарч, ДАШТ-ээс 1974 онд хүрэл, 1975 онд мөнгөн, медалийудыг тус тус хүртжээ. Мөн Дэлхийн оюутны их наадам “Универсиад-73”-аас анхны алтан медалийг эх орондоо авчирсан бол 1975 онд АНУ-ын Толидо

хотод зохиогдсон Дэлхийн шилдэг багуудын цомын төлөө тэмцээний мөнгө, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 1973 онд алт, 1974 онд хүрэл медалийг тус тус авсан юм.

Тэрээр Болгарын “Дан-Колов”, Германы “Зилэн”-ийн нэрэмжит олон улсын тэмцээнүүдээс тус бүр алтан медаль, Улаанбаатар хотноо явагддаг уламжлалт “Интернациональ” тэмцээнд таван жил дараалан түүрүүлсний дээр Иран, Польш, Чехословак, Унгар, Турк, ОХУ болон бусад орнуудад зохион явагдсан тэмцээнүүдэд удаа дараалан амжилттай оролцож 50 шахам алт, мөнгө, хүрэл медалийг хүртсэн бөгөөд улсын аварга шалгаруулах тэмцээнд дөрвөн удаа аварга болж байв.

Ц.Нацагдорж нь зөвхөн залуу насны эр бяраар хүчээрээ дэлхийн давцанд улс орныхоо нэрийг мандуулж явсан төдийгүй 1995, 1996 онд Болгарт явагдсан Ахмадын ДАШТ-ээс хошой алтан медаль, 1997 онд Швейцарь улсад явагдсан ДАШТ-ээс мөнгөн медаль авч 60 шахам насандаа төрийнхөө алтан соёмбот далбааг дэлхийн тавцанд мандуулж явсан манай алдарт бөх юм.

Ц.Нацагдорж нь алдартай тамирчин байсан төдийгүй авьяаслаг сайн дасгалжуулагч, сурган хүмүүжүүлэгч байсан юм. Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин дархан аварга Б.Бат-Эрдэнэ, МУ-ын арслан, гавьяат тамирчин Д.Мөнх-Эрдэнэ, МУ-ын заан Д.Хишигдорж, Ч.Бямбадорж, С.Сүхбаатар, улсын начин Н.Түмэннаст, Ш.Лхагвасүрэн, С.Баатар, Д.Цогтгэрэл, Д.Амаржаргал, Г.Бат-Амгалан, аймгийн арслан А.Пүрэвжав, Н.Баярмагнай, Г.Батпүрэв нарын зэрэг олон арван бөхчүүдийг бэлтгэн гаргасан бөгөөд шавь нар нь одоог хүртэл зүлэг ногоон дэвжээндээ багшийнхаа заасан бөхийн эрдэм, ёс жудгаар төрийн наадамд алдар цолоо дуудуулан барилдаж байгаагийн дээр төр түшицлэж, түмэн олонхоо төлөө зүтгэж явна. Ц.Нацагдоржийн чөлөөт бөхийн спортыг хөгжүүлэхэд гаргасан уйгагүй ажиллагаа, хөдөлмөрийн үр дүнд түүний бэлтгэн дасгалжуулсан баг тамирчдаас нь Монгол улсын гавьяат тамирчин Б.Болд, Олон улсын хэмжээний мастер С.Сүхбаатар, Ч.Бямбадорж, Н.Лхамсүрэн, Г.Хишигдорж нарын зэрэг алдарт бөхчүүд төрөн гарсан байна.

Талийгаачийн улс орныхоо төлөө зүтгэсэн нөр их хөдөлмөр, шулуун шударга, ажилч хичээнгүй, нөхөрсөг зан чанар бидний сэтгэл зүрхэнд үүрд дурсагдах болно.

Түүний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, ах, дүү, найз нөхдөд нь гүн эмгэнэл илэрхийлэе. Ум сайн амгалан болтугай.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биесийн тамир, спортын газар, Монголын үндэсний олимпын хороо, Монголын чөлөөт бөхийн холбоо, Биесийн тамир, спортын “Хүч” нийгэмлэг

Израил араб хэлийг албан ёсны хэлнээс хасчээ



Израилын Засгийн газар энэ сарын 7-ны өдрийн хуралдаанаар өөрийн улсаа “иуд үндэстний өлгий нутаг” хэмээн тодорхойлж, Араб хэлийг албан ёсны хэлнээс хасах тухай хуулийн төслийг баталжээ.

Орон нутгийн “Haaretz” сонинд бичсэнээр тус хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлбэл араб хэл албан ёсны

хэл биш болох хэдий ч, палестинчууд зэрэг араб хэлээр ярилцдаг иргэд төрийн аливаа үйлчилгээг авахдаа тусгай статустайгаар араб хэлээр авах эрхтэй гэдгийг тусгаж өгчээ. Улмаар тус хуулийн төслийг Үндсэн хуулийн зарим зүйл заалттай уялдуулан, еврей хэлийг “Үндэсний хэл” хэмээн тодорхойлж өгсөн байна. Израилын хүн амын 17.5

хувийг араб гаралтай иргэд эзэлдэг аж. Тиймээс одоогоор еврей болон араб хэлийг аль алиныг нь байгууллагын хаяг, заавар, зар сурталчилгаа, төрийн аливаа үйлчилгээнд ашигладаг байна. Гэхдээ хууль хэрэгжиж эхэлснээр дээрх сурталчилгаа, хаяг гэх мэтэд аль хэдийг ашиглах нь одоогоор тодорхойгүй байгааг эх сурвалж онцолж байна.

ОНЦЛОХ ХУУДАС

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ХУУЛЬ ХЭРЭГТЭЙ, ХЭРЭГГҮЙ

Эсрэг тэсрэг байр суурь

Б.Жавхлан: Хууль батлагдсанаар банкуудын бизнесийг булааж авахгүй



/УИХ-ын гишүүн/

-Банкууд уг хуулийг эсэргүүцэж байгаа гэж бодохгүй байна. Банкуудын хувьд энэ хуультай зохицож ажиллах хэрэгтэй. Хууль батлагдсанаар банкуудын бизнесийг булааж авах гэж байгаа, эсхүл шинэ хуваарилалт хийх гэсэн зорилго огт байхгүй. Нэг зүйлийг олж харах ёстой. Санхүүгийн зах зээлийн нийтлэг эрх ашиг олон нийтийн төлөө байх хэрэгтэй. Нийт санхүүгийн зах зээлийн эцсийн хэрэглэгчдийн төлөө төрийн болон арилжааны банкны бүх зохицуулалт, үйлчилгээ явагдаж байдаг. Олон нийтийн эрх ашиг, эрэлт хэрэгцээ юунд чиглэж байна вэ гэхээр урт хугацаатай, өртөг багатай, хүү багатай, тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүн рүү хандаж байгаа. Тэгэхээр өнөөдөр бидэнд зайлшгүй хэрэгтэй байгаа зүйлийг зах зээл рүү хэн нийлүүлж чадах вэ. Үүнд төрийн зохицуулалт хийж, нээлттэй бодлого барих ёстой. Нөгөө талаасаа гэвэл энэ нь өрсөлдөөн. Өрсөлдөөнийг төр дэмжих ёстой. Ард олон болон эдийн засагт хохиролгүй байдлаар өрсөлдөөнийг дэмжжэ. Ер нь банкууд сүүлийн 27 жил шинэ тогтолцоогоороо маш сайн хөгжиж ирсэн. Ард иргэдэд санхүүгийн үйлчилгээг маш сайн хүргэж байгаа. 2000 оноос хойших бизнесүүдийг хараад байхад банкны салбар шиг технологийн дэвшил хийж, дэлхийн стандартыг нэвтрүүлж байгаа салбар цөөхөн. Яахав сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар хөгжиж байгаа. Гэхдээ хөгжлийн түвшнээрээ банкны систем тэргүүлж байгаа гэж боддог. Цаашид манай улсын эдийн засаг тэлнэ. Тэлэхийн хэрээр санхүүгийн хэрэгцээ улам нэмэгдэнэ. Түүнийг банкны систем дангаараа хангаж чадах уу, үгүй юу гэдэг асуудал гарна. Хэдийгээр банкны систем хөгжөөд байгаа ч гэлээ нөгөө талдаа хоёр дахь санхүүгийн зах зээл болох хөрөнгийн зах зээлээ хөгжүүлж чадаагүй. Тиймээс банкны зах зээлийн эх үүсвэр ганцхан хадгаламжийн тогтолцоон дээр тогтож ирсэн. Хэрэв хөрөнгийн зах зээл адилхан хөгжөөд ирсэн бол банкууд ганцхан хадгаламж биш хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт татаж хямд өртөгтэй, бага хүүтэй зээл олгох боломж бүрдэх байсан. Ингэж чадаагүй болохоор хадгаламжийн хүүгээрээ өрсөлдөж өнөөдрийг хүрлээ. Тиймээс санхүүгийн зуучлалын бүтээгдэхүүний үнэ буурч өгөхгүй байгаа юм. Гадны банк манай улсад орж ирэх эсэх нь цаг хугацааны л асуудал. Одоогоос зургаа, долоон жилийн өмнө буюу эдийн засаг мундаг өссөн байх үед ийм хуультай байсан бол гадны банкууд уралдаад орж ирэх байсан биз. Харин өнөөдрийн эдийн засгийн өсөлтгүй, идэвхжилгүй, бизнес зогссон, улсын ээлжлэх зэрэглэл –В түвшинд очихсон байхад хэн манайд бизнес хийх гэж орж ирэх вэ дээ. Тийм байлаа гээд энэ хуулийг хойшлуулж болохгүй.

Эх сурвалж: Өдрийн сонин

Сэтгүүлчийн дүгнэлт

ГАДНЫ БАНКУУДАД ГАЗАР НУТГАА АЛДАЖ ДУУСАХ ВИЙ

Б.ТОГТОХ

Гадны банк, санхүүгийн байгууллагыг Монгол Улсад ажиллуулж, улмаар банкны салбарт өрсөлдөөн бий болгох тухай яриа 2012 оноос хойш эрчимтэй яригдсан. “Банк оф Чайна” Монголд салбараа нээх тухай яриа гардаг ч, тэр хэрээр шүүмжлэл дагуулдаг байлаа. Дотоодын монополь болсон хэдхэн банкуудын дархлагдсан эрх мэдэл, дураар авирласан ааш араншинг дарахын тулд Монголд гадны банк орж ирэх ёстой. Тэгж байж банкны салбар өрсөлдөөнтэй болж, хэрэглэгч банкаа өөрөө сонгож үйлчлүүлдэг болно. Банкнаас зээл авахын тулд зээл авах шаардлагагүй гэдгээ нотлохуйц баян байх шаардлагагүй болох билээ. Ард түмний амьжиргааны хэдэн мал, цалинг нь барьцаалчихаад “шүлс” төдий мөнгө өгдөг арилжааны нэртэй ч ломбардны зарчимтай газруудын ханд нь хага дарагдах учиртай. Бодит үнэн ийм л байгаа. Монголд арилжааны зорилгоор үйл ажиллагаа явуулж буй 14 банкаас нэг нь ч иргэдийн эрх ашигт нийцсэн үйлчилгээ явуулдаггүй. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах эсэх нь ч төрийн гаргасан шийдвэрээр бус банкны эздийн хүслээр шийдэгддэг. Цаашлаад, цалингийн зээлийн хүүг хэд байлгахаа тэд өөрсдөө л шийднэ. Хэний бизнесийг дэмжиж, хэнд боломж олгох нь мөн л эздийн таашаах шийдвэр. Гэхдээ тэдний үндсэн хөрөнгө нь өөрөө “шүлс” төдий.

Том төсөл хөтөлбөр, шинэ санал, санаачилга, инновацийг дэмжих бус эсрэгээрээ байгууллагын ажилчдын цалин, байр, машины зээл олгох төдий л хөрөнгөтэй байдаг. 100 сая төгрөгийн төсөл хөтөлбөр санхүүжүүлэх бядтай банк тэдэн дунд тун цөөхөн байгааг нуугаад яахав. Тиймээс гадны банк санхүүгийн байгууллагад Монгол Улс үүдээ нээхэд буруу зүйл байхгүй билээ. Гэхдээ хяналт хамгийн чухал. Цаашлаад эдийн засаг хүндхэн, иргэдийн амьдрал хэцүү, компани, аж ахуйн нэгжүүд эхнээсээ хаалгаа барьж буй энэ үед гадаадын банк санхүүгийн байгууллагад үүдээ нээх нь хэр зөв шийдвэр вэ. Дотоодын банкныхаа шалгуурыг давж чадаагүй нэг нөхөр газраа барьцаанд тавиад гадны банкнаас зээл авчихлаа гэж боддөг. Тухайн үедээ амархан зээл нь бүтэж, ажлаа эхлүүлэх ч эдийн засаг хүнд үед эргээд дампуурлаа зарлахгүй гэх баталгаа алга.

Тэр цагт компанийн эзнийн газар, бүх үл хөдлөх хөрөнгө Монголын банкинд биш гадны банкны мэдэлд очих нь тодорхой юм. Тиймээс л УИХ-аар хэлэлцэж буй Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль цаг үеэ олсон уу гэдэг нь яах аргагүй эргэлзээ дагуулж буй юм. Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль баталж, гадны банк санхүүгийн байгууллага Монгол Улсад салбараа нээх боломжийг бүрдүүлснээр зээлийн хүү буурч, банк санхүүгийн салбарт өөрчлөлт хийгдэж, өрсөлдөөн нэмэгдэх давуу талтай хэмээн хууль санаачлагч Б.Жавхлан нарын гишүүд тайлбарлаж байгаа. Мэдээж эдгээр банкууд иргэнд цалин олгож, халамж тараагаад суухгүй. Үндсэн дүрмийн сан нь 500 тэрбум гэсэн шалгуур байгаа учраас том хөдлөх нь тодорхой байгаа юм. Манайд салбараа нээх хүсэлтээ гаргасан, сонирхож буй банк, санхүүгийн байгууллагууд ашиггүй зүйлд хөрөнгө оруулж, эрсдэл гаргах нь юу л бол.

Тиймээс уул уурхайн салбар, цаашлаад Монгол Улсын газар нутаг, ашигт малтмалд санаархсан далд сонирхол нуугдаж байна уу гэдэгт анхаарал хандуулах учиртай бус уу. Монгол Улсын Төрийн тэргүүн чуулганы индрээс энэ асуудлыг онцолж хэлсэн нь гадны банкуудын лоббигоор хийгдэж байгаа хууль юм биш биз гэх хардлага төрүүлж байгаа юм. Монгол Улсын газар нутгийн барьцаалах, том компаниудад тэрбум тэрбумаар нь зээл олгож, улмаар зээлээ төлж чадахгүй бол газрыг нь барьцаалахгүй гэсэн баталгааг өнөөдөр хэн ч өгч чадахгүй байгаа. Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой ч газар тариалан, төмс хүнсний ногоо эрхэлж буй олон мянган аж ахуйн нэгжийн газар гадаадын банкны мэдэлд очвол хэрхэх билээ. Энэ мэтээр маш олон эрсдэл дагуулсан хуулийг УИХ тун удахгүй эцэслэн батлах нь. Баталсны дараа мянга түм эсэргүүцээд ч нэгэнт өнгөрсөн байх вий. Тиймээс сөрөг хүчний гишүүд ажлаа хийж, хяналт тавих шаардлагатай байна.

Яаран сандран энэ хуулийг олонхиор хүч түрэн батлуулж буй далд зорилгыг мэдмээр байгаа юм. Монголын баялаг, газар нутагт эзэн суух гэсэн чин хүслээ тэд төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах нэрийн дор нууж байгаа юм биш биз. Банкны салбарт өрсөлдөөн бий болгох бус эсрэгээрээ монголын бүх компани, аж ахуйн нэгжүүдийг барьцаалах хүсэл байгаа ч юм бил үү. Хэнд ч хардах эрх бий. Монголын бүх мал, эзэдтэйгээ хамт арилжааны ганц нэгхэн банкны эрхшээлд орчихсон нь худлаа биш. Тод удахгүй бүх аж ахуйн нэгж, компаниуд газартайгаа хамт гадны банкны мэдэлд орохгүй гэсэн баталгаа хаана ч алга. Энэ хуулийг төслийг эргэж нягтлах, эдийн засгийн хүнд хэцүү цаг үед батлахгүй байх арга чарга алга уу, улстөрчид өө. Баталлаа гэхэд зүйл заалт бүрийг нь долоо хэмжиж нэг огтлох зарчмаар сайтар хэлэлцээрэй гэж хүсье.



Ц.Элбэгдорж: Монгол Улсын газрыг барьцаалах эрх олж авч байна

/Монгол Улсын Ерөнхийлөгч/

-Хөрөнгө оруулалтын банкны хууль гээд хуультай холбогдсон Банкны хуульд өөрчлөлт оруулж байгаа. Уг нь бид ярьж байгаад тохирсон.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэхээр бол УАБЗ дээр ярина. Ингэж ярьдаг асуудал шүү гэж. Гэтэл энэ дотор нэг юм хавчуулж орж ирээд, УИХ-ын гишүүд их болгоомжилсон байдлаар асуугаад байгаа. Ажлын хэсэг, санаачилсан улсууд нь тойруулж хариулт өгөөд яваад байгаа. Үүнд онцгой анхаарах ёстой шүү. Үүний цаана юу байгаа вэ гэхээр ерөөсөө Монгол Улсын газрыг барьцаалах эрхийг л олж авч байгаа юм. Монгол Улсын ашигт малтмалыг барьцаалах эрхийг олж авч байгаа юм. Өнөөдөр гаднын хөрөнгө оруулалт давамгайлсан аж ахуйн нэгжүүд, банк, санхүүгийн байгууллага Монгол Улсын газрыг барьцаалах эрх байхгүй. Ашигт малтмалын лицензийг барьцаалах эрх байхгүй. Эхлээд тэд барьцаална. Дараа нь аж ахуйн нэгж, иргэд барьцааны зээлээ төлж чадахгүй болно.

Тэгээд барьцаалагдсан газар тэр байгууллага, тэр талын өмч болж хувирина. Цааш наашаа зарагдана. Ингээд Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдлын асуудал, санхүү, эдийн засгийн бие даасан байдлын асуудалд онцгой хохирол учрах боломж байгаа юм. Үүнийг бид өмнө нь ярьж байсан. Та бүхэн онцгой анхаараарай гэдгийг хэлмээр байна. Хөрөнгө оруулалтын банкны хууль гэдэг юман дотор Монголын хувь заяанд онц ноцтой аюул учруулах хутга дундуур нь, далдуур оруулаад ирж байгаа юм биш биз дээ. Үүнд УИХ онцгой анхаарах хэрэгтэй. Энд УАБЗ-ийн Ажлын албаны хүмүүс оролцож, ажиглаж харж байгаа. Гаднын банк, барьцаатай холбоотой асуудал дээр энэ хуулийн бусад зохицуулалтыг гаргаад, үүнтэй холбогдсон газар, үндсэн хөрөнгө барьцаалах, бусад зүйлүүдийг энэ хуулиас бүрэн авч хаях шаардлагатай шүү. Явж явж Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдал, энэ бүхэнтэй эргэж холбогдоно шүү. “Хүн нь чухал биш ээ. Газар нутаг нь чухал. Баялаг нь чухал” гэж хэдэн зуун жилээр бодлого явуулж, үүнийгээ гүйцэлдүүлэхийн төлөө явдаг юм бий. УИХ-ын гишүүд үндэснийхээ эрх ашиг гэдэгт онцгой анхаарах ёстой гэж бодож байгаа. УИХ-ын гишүүд санаа зовж асуугаад байгаа. Гэхдээ орж ирсэн зүйлийн өгч байгаа тайлбар нь хангалттай биш байна. Шаардлагатай бол энэ хуульд орсон энэ зохицуулалтыг УАБЗ дээр авч хэлэлцгээ хуулийн хэлэлцүүлгийг хойшлуулах хэрэгтэй гэж бодож байгаа. Ер нь гаднын банк, санхүүгийн байгууллагуудад эрх олгох асуудлаар УАБЗ-өөр заавал ярьдаг. Энд яриад шийдсэн шийдлээр төрийн бүх байгууллага ажилладаг, ийм болтэй гэж бид өмнө нь ярьж тогтсон гэдгийг та бүхэнд сануулж хэлбэ.



Л.Мөнхбаатар: Бие даасан хууль байх эсэхэд эргэлзэж байна

/УИХ-ын гишүүн/

-Хөрөнгө оруулалтын хуулийг заавал бие даасан хууль байх шаардлага байгаа эсэхэд эргэлзэж байна. Давхардуулан заахгүй гээд бие даасан хуульд тавигдах шаардлага буюу 23-р зүйлд тодорхой заалтууд бий. Банкны хуультай харьцуулахаар 80 орчим хувь нь давхардсан шинжтэй байна. Мэдээж эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай боловч банкны тухай хуульд нэмэлт оруулах маягаар явуулах саналтай байна. Хоёрдугаарт, энэ хуулийн 6.1.6-д Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил үйлчилгээг Хөрөнгө оруулалтын банк явуулж болно гэж заасан нь бүр нээлттэй болгосон юм биш үү. Хязгаарласан биш нилээн задгай тавьсан нь ажиглагдаж байна. Гуравдугаарт, хуулийн үзэл баримтлалыг уншихаар гадаадын хөрөнгө оруулалттай банк гэсэн өгүүлбэр явж байна. Гэвч зохицуулалт нь гадаадынхаас гадна дотоодын үндэсний хөрөнгө оруулагч нар ч байж болохоор харагдаж байна. Үүнийгээ илүү оновчтой болгох хэрэгтэй байна. Монголд нэг жилийн хугацаанд төлөөлөгчийн газраа байгуулж, үйл ажиллагаа явуулсан банкууд хөрөнгө оруулалтын банк байгуулж болох хуулийн заалттай юм байна.

ЧУХАЛ ХҮН

Р.ЖИГЖИД: ГАЗАР ТАРИАЛАН, ХОСОЛСОН ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛД

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Уул уурхайн сайд асан Р. Жигжидтэй уулзаж ярилцлаа. Түүнтэй ярилцах сэдэв маш олон. Монгол-японы харилцаанаас авахуулаад уул уурхайн салбарын хөгжлийн чиг хандлагын талаар ялбар бодол, дүгнэлттэй явдгийг нь уншигч танд хүргэж болно. Асуудлыг зөв бөгөөд зөвлөн талаас нь харгахыг чухалчилдаг нь энэ хүний эрхэл чанар байж мэднэ. Дипломат албанаас төрийн сайд болсон цөөн улс төрчийн нэг тэрбээр эдүгээ монгол-японы хөрөнгө оруулалттай "everyday farm" компаний гүйцэтгэх захирлын албыг хашихаас гадна хоёр ч төрийн бус байгууллагыг тэргүүлэхийн зэрэгцээ хүлүүлээгийн үйлсэд хүчин зүтгэж байна. Түүнийг "Чухал хүн" буландаа уриалаа.

-Тантай харьцдаг албаны хүмүүсийг гурван бүлэгт хувааж болохоор аж. Нэг хэсэг нь таныг Элчин сайд аа гэж байхад нөгөө нь уул уурхайн сайд, захирал аа хэмээх юм. Харин төрийн бус байгууллага болоод хүмүүнлэгийн үйлсэд хүчин зүтгэж байгаа нөхөд тань хэн гэж дууддаг вэ?

-Сэтгүүлчид их ажигч хүмүүс шүү. Миний юу хийж явааг хэдийнэ судалж амжсан байх шив. Үүнийг хэлэхэд, би гурван байгууллагын харьяалалтай болсон байна. Эхнийх нь таны хамгийн сүүлд тодотгож асуусан "Монгол-Японы харилцааг дэмжих түншийн холбоо" төрийн бус байгууллага. Туншийн холбооны дэд ерөнхийлөгчөөр Ерөнхий сайд асан д.содном гуай ажилладаг юм. Дараагийнх нь "Монгол-Токуда" сан. Уг санг Токушюкай группын ерөнхийлөгч, Японы парламентийн гишүүн асан Т. Токуда тэргүүлдэг. Энэ эрхэм Монгол Улсын эрүүл мэндийн салбарт тулгамдаж байсан олон асуудлыг шийдэхэд маш их хувь нэмэр оруулсан нэгэн. Түүний санаачлагаар "Монгол-Токуда" сан 2011 онд байгуулагдсан. Миний хувьд энэхүү сангийн удирдах зөвлөлийн гишүүн. Нэгэнт сангийн талаар ярьж эхэлсэн болохоор зарим зүйлийг тодотгох нь зөв байх. "Монгол-Токуда" сан манай улсын эрүүл мэндийн салбарт хандивын үйл ажиллагаа явуулахаас гадна эх ялхасын эрүүл мэндийн төв, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвд болон Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт гемодиализийн тасаг байгуулж, тус бүр таван ширхэг диализийн аппарат бэлэглэснээс гадна Улсын төв нэгдүгээр эмнэлэгт хиймэл бөөрний төв байгуулан 10 ширхэг диализийн буюу хиймэл бөөрний аппарат суурилуулж өгсөн. Түүнчлэн аппарат ажиллах тасаг, төвд ажиллах боловсон хүчнийг сургаж, дадлагажуулж өгдөг. Гуравдугаарт нь миний одоо ажиллаж буй сэргээгдэх эрчим хүч, хөдөө аж ахуйн чиглэлийн "Моннаран" төсөл. Нөгөөтэйгүүр, Монгол-Японы хамтын ажиллагааны нийгэмлэг харьцангуй олон. Тэр дундаа Японд бол бүр ч олон. Ор нэр төдий бус бодитоор үйл ажиллагаа явуулдаг нь Монгол-Японы харилцааг дэмжих түншийн холбоо болон Монгол-Японы найрамдлын нийгэмлэг. Энэ хоёр төрийн бус байгууллага бусдыгаа тэргүүлж, голлох үүрэгтэйгээр ажилладаг юм. **-Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн баярын арга хэмжээний үеэр Гадаад хэргийн сайд "Бүрэн эрхт Элчин сайд Р. Жигжид бол хоёр орны найрамдалт хамтын ажиллагаанд их зүйлийг хийсэн хүн хэмээн онцлон тэмдэглэж байсныг санаж байна. Чухам тэр мөчид танд юу бодогдож байсан бэ?**

онд албан ёсны дипломат харилцаа тогтсон түүхтэй. Тэр он жилүүдийг эргэн санахад үед хүйтэн дайн үе байлаа шүү дээ. Цаг үеийн нөхцөл байдал хэдий тийм байсан ч бид бие биедээ найрсаар ханддаг байсныг онцолж хэлэх ёстой. Ингэж явсаар 1990-ээд оны эхнээс хоёр орны харилцаа маш идэвхтэй болж ирсэн. Монгол Улс ардчилсан нийгэмд шилжих үйл явцыг Япон улс анхнаас нь дэмжсэн. Миний хувьд Японд 1996-2000 онд улс төрийн зөвлөх, 2004-2006 онд Элчин сайдын зөвлөх, 2006-2011 онд Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажилласан. Улс төрийн зөвлөхөөс Элчин сайдаар ажилласан онуудад Монгол Улс ардчилсан нийгэм рүү шилжих шилжилтийн үе тохиосон юм. Тэр үед бидэнд эдийн засгийн хамтын ажиллагаа, түүн дотроо Засгийн газрын шугамаар орж ирэх зээл тусламжийн хэмжээг ахиулан авах явдал байсан. Үүний тулд улс төрийн сайн харилцаатай байж улс төрийн дэмжлэг авах явдлыг чухалчилж байв. Япон улс манай улсыг бүхий л талаар талаас дэмжиж байлаа. Харин 2004-2011 онд улс төр, эдийн засгийн нөхцөл байдал өөр болсон. Тодруулбал, Монгол Улсын эдийн засаг сайжирч, буцалтгүй тусламж бус эдийн засгийн хамтын ажиллагааны талаар ярьж эхэлсэн. Өрөөр хэлбэл, бид гадны улс орнуудаас авсан зээлээ төлөх бяртай болж ирсэн гэсэн үг. Үүнтэй зэрэгцээд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, худалдааны салбар дахь харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнөж эхэлсэн. Ийм орчин нөхцлийг бүрдүүлэхийн төлөө хоёр талын Элчин сайдын яамд хичээн зүтгэсэн. Тэр үед хоёр улсын харилцаа иж бүрэн түншлэлийн зарчмаар явж байсан юм. Бидний цаашдын зорилго тухайн үед иж бүрэн түншлэлээс стратегийн түншлэл рүү шилжих явдал байлаа. Үүнийг хэрэгжүүлэхэд гар бие оролцсондоо би хувьдаа баяртай явдаг. Эдийн засгийн харилцааны хувьд эдийн засгийн түншлэлийн гэрээ буюу худалдааны гэрээг байгуулах том зорилтыг хоёр тал давшуулсан. Энэ том алхмын үндэс суурийг би бас тавилцсан гэж боддог. Үүнээс гадна Японы Гадаад яаманд манай асуудлыг хариуцдаг байсан нэгжийн нэрийг өөрчлүүлж чадсан явдал. Өмнө нь манай асуудлыг Хятадын хэлтэс хариуцдаг байсан юм. Нэг ёсондоо Хятадын асуудал дотор манай асуудал яригддаг байлаа шүү дээ. Жижиг мэт санагдаж болох ч Монгол Улсын хувьд том асуудлыг шийдүүлэхийн төлөө хөөцөлдсөний эцэст Япон улс Гадаад яамны хуульдаа өөрчлөлт оруулж, Хятад-Монголын хэлтсийг шинээр байгуулсан. Энэ нь хоёр улсын харилцаанд чухалд тооцогдох үйл явдал мөн билээ. **-Та эдүгээ Элчин сайд бус хүмүүнлэг, төрийн бус байгууллагын элч төлөөлөгч болжээ.**

"Токушюкай" группыг үндэслэн байгуулагч нь ноён Т.Токуда сан. Буй бүхнээ хүний сайн сайхны төлөө зориулсаар ирсэн энэ хүн тосгонд, ядуу тариачны гэр бүлд төрж өссөн нэгэн. Түүний бага нас маш хүнд нөхцөлд өнгөрсөн байдаг. Нэгэн удаа дүү нь хүнд ханиад тусч эмнэлгийн тусламж авах шаардлага гарч л дээ. Харамсалтай нь тосгон ганцхан эмчтэйн дээр шөнө болсон байсан тул тусламж авч чадалгүйн дүүгээ алдаж. Чухам тэр үед л мөнгөтэй хүнд нийгэм үйлчилдэг болохыг яс махандаа тулгал мэдэрсэн гэдэг. Хожим арван жилээ төгсмөө өө анагаах ухааны сургуульд элсэн суралцаж, дараа нь амь насаараа дэнчин тавьж байж зээлээр эмнэлэг

байгуулсан түүхтэй. Токуда гуайн туйлын зорилго эрүүл, амьд явахад хүн бүр тэгш эрхтэй гэх үзэл. Энэ үзэл бодол, байр суурийнхаа төлөө бүх насаараа зүтгэж яваа буянтай буурал. Эдүгээ түүний байгуулсан анхны эмнэлэг өргөжин хөгжиж, дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаагаа явуулж буй. Та бүхэн бод доо, 70 нэгдсэн больниц, 31 клиник оношлогооны төв, 76 асрамжийн газрыг байгуулсан байх юм. Ноён Токуда 1990 онд Японы парламентэд дөрвөнтөө нэр дэвшиж сонгогдсон нэгэн. Манай оронд Японы доод танхимын гишүүн байхдаа ирж байсан юм. Тухайн үед манайд эмнэлэг байгуулах гэсэн төлөвлөгөө нь бүтээгүй тул

Болгарт 600 ортой эмнэлэг байгуулсан нь эдүгээ өргөжиж 1000 ортой болсон. Үүнийг мөн л өөрийнхөө хөрөнгөөр байгуулсан. Харамсалтай нь тэрбээр 2002 онд маш хүнд, хэдэн зуун мянгад нэг тохиох өвчин туссан. Ухаан санаа нь эрүүл атлаа биений бүх булчин нь суларсан. Эрүүл мэндээсээ болж улс төрийг орхин зөвхөн дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж байгаа сүлжээ эмнэлгүүдийнхээ үйл ажиллагааг оюун ухаанаараа удирддаг болсон. Хэдийгээр 24 цагийн асаргаа, сувилгаанд байдаг ч нийгмийн сайн сайхны төлөө цаг нартай уралдан хөдөлмөрлөж байгааг нь хүндлэхээс өөр аргагүй юм. Тэрбээр хүнтэй уулзахдаа нүдээрээ үсэг рүү зааж түүнийг нь үг өгүүлбэр болгох маягаар ойлгогшдог. Би энэ хүнийг 1990-ээд оны эхээр Монголд ирэхэд орчуулагчаар нь ажиллаж танилцсан. Сүүлд Элчин сайдаар ажиллаж байхдаа ноён О.Миятоогоор дамжуулж уулзахдаа өмнө нь ярьж байгаад орхисон эмнэлэг байгуулах талаар санал солилцож, улмаар "Монгол-Токуда" санг үүсгэн байгуулж, Монголын талыг хариуцан ажиллах болсон.

байгаа. Гэсэн хэдий ч Монгол Улсын эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай бүхий л тоног төхөөрөмж, эд зүйлсээр дэмжлэг үзүүлэх, боловсон хүчнийг бэлтгэхэд туслах хүсэл эрмэлзэлтэй гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Бид саяхан эрүүл мэндийн салбарт юу хэрэгцээтэй байна вэ гэдгийг судалж үзэхэд, эмнэлгийн зориулалттай ор, түргэн тусламжийн машин дутагдалтай байгааг олж мэдсэн. Хамгийн гол нь хүн сэтгэл амар амь насаа даатгах эмнэлэгтэй болох нь ноён Токудагийн нэн тэргүүний зорилго байдаг.

...Миний хувьд Японд 1996-2000 онд улс төрийн зөвлөх, 2004-2006 онд Элчин сайдын зөвлөх, 2006-2011 онд Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажилласан. Улс төрийн зөвлөхөөс Элчин сайдаар ажилласан онуудад Монгол Улс ардчилсан нийгэм рүү шилжих шилжилтийн үе тохиосон юм. Тэр үед бидэнд эдийн засгийн хамтын ажиллагаа, түүн дотроо Засгийн газрын шугамаар орж ирэх зээл тусламжийн хэмжээг ахиулан авах явдал байсан. Үүний тулд улс төрийн сайн харилцаатай байж улс төрийн дэмжлэг авах явдлыг чухалчилж байв...

-Дэлхийн олон оронд байгуулсан түүний эмнэлэг хандив уу эсвэл эргэн төлөгдөгдөх нөхцөл бүхий зээл байдаг юм уу?

-Хандив, буцалтгүй тусламжийн хүрээнд баригддаг. Монгол-Токуда сан бол төрийн бус байгууллага.

-Таны дараагийн ярих сэдэв бол сэргээгдэх эрчим хүч Монгол Улсад дөнгөж хөгжиж байгаа салбар?

"Everyday farm" бол Монгол-Японы хамтарсан хөрөнгө оруулалт бүхий компани. Японы тал дийлэнх хөрөнгө оруулалтыг хийсэн. Манай компани анх 2004 онд хөдөө аж ахуй, тэр дундаа хүлэмжийн аж ахуйг Монголд нэвтрүүлсэн. Толгой компани маань Японы farmdo групп. Японд нэр хүнд бүхий хөдөө аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж. Тэгэхээр та бүхэн

-Сангийн хэтийн төлөвлөгөөг Улаанбаатар хотноо эмнэлэг байгуулах явдал гэж ойлгож болох уу?

-Тийм ээ. Иж бүрэн оношлогоо бүхий эмнэлэг байгуулах явдал. Гэхдээ хэзээнээс ажил хэрэг болох вэ гэдэг нь тодорхойгүй

Solar Farm: Газар тариалан, сэргээгдэх эрчим хүчний хосолсон технологи



"Монгол-Токуда" сангийн тэргүүн Т. Токуда.

Тэрбээр Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсээр ирсэн байна. Түүний чин сэтгэлээсээ өгсөн Диализийн аппаратыг Улсын төв эмнэлэг, Налайх дүүргийн эмнэлэг, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт ашиглаж буй.

Cardiac Angiography system

Digital Subtraction Angiography (DSA)

Robotic Tel Surgery (ZEUS)

ЧУХАЛ ХҮН

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ
НУТАГШУУЛЖ БАЙНА



Гэрэл зургийг Т.АРТУУЖИН

хөдөө аж ахуйн компани яагаад сэргээгдэх эрчим хүч рүү орсон юм бэ гэж асуух нь дамжиггүй. Японд хөдөө аж ахуй эрхэлдэг хүний тоо харьцангуй цөөрч залуучууд нь хот руу шилжих болсон нь энэ салбарт хүндээр тусч тариалангийн талбайнууд эхнээсээ эзгүйрсэн. Тиймээс "Farmdo" компани ашиглахаа больсон талбайг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд эрчим хүчний нарны панел байгуулж, түүнийгээ дор давхар тариалалт хийх болсон юм билээ. Өөрөөр хэлбэл, нэг сумаар хоёр туулай буудсан хэрэг. Панелийг битүүмжлэхээр хүлэмж болж буй юм. Компаний санаачлагийг Засгийн газар нь дэмжиж, өндөрүнээр худалдаж авсан нь эдүгээ Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн сэргээгдэх эрчим хүчний "Моннаран" төсөл. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр хүлэмжинд хөрс ашиглахгүйгээр усан боломж бүрдэх учиртай. Түүнчлэн шинэ орчин нөхцөл бүрдэнэ. Ногоочид шороотой зуурагдахгүйгээр хүнсний ногоог хүлэмжинд тарьдаг болно гэсэн үг.

-Миний ойлгосноор шилдэг үрслүүлдэггүй адил технологийг хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлж байна гэсэн үг үү?

-Зөв ойлгосон байна. Хөрс нь усан дотроо хөвөн байрлаж түүнийгээ тусгайлсан бордоогоор тэжээж ургуулна гэсэн үг. Өнөөдрийн байдлаар бид гүзээлзгэнэ, өргөст хэмх, улаан лооль гэх мэт хүнсний нарийн ногоог туршилтаар тариалж байна. Харин сэргээгдэх эрчим хүчнийг хөгжүүлэх болсон шалтгаан нь нүүрстөрөгчийг хэмнэх зорилготой. Тэгэхээр нүүрстөрөгч бага ялгаруулдаг технологийг Монголд нэвтрүүлэхийг Японы засгийн газар бодлогоор дэмжиж байгаа юм.

-Мэдээж төслийн ар талд санхүүгийн нарийн тооцоо буй. Ямар ч улс орон

хөрөнгө мөнгөө үр ашиггүй зүйлд зарцуулахгүй. Хоёр улсын аль алинд нь ашгаа өгөхүйц төсөл гэдгийг хэн баталж нотолсон юм бэ?

-Энэхүү төслийн цаана дэлхий дахинд нэр хүндтэй "Хитачи" мөн "Энникс" фирм мэргэжлийн зөвлөгөө өгч ажилладаг. Монгол Улс сэргээгдэх эрчим хүч түүн дотроо нарны эрчим хүчний асар их нөөцтэй гэсэн судалгааг тэд хийсэн байдаг. Бүтэн жилийн турш нартай байдаг, хуурай цаг агаар зэргээс гарах ашигт үйлийн коэффициент нь өндөр гарсан байна лээ. Тийм учраас манай улсыг сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой нь гэж үзсэн. Тэгээд ч Монгол Улс сэргээгдэх эрчим хүчнийг хөгжүүлэх бодлого баримтлаж буй. Нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 20 хувь хүртэлх хувийг сэргээгдэх эрчим хүчээс хангахаар төлөвлөсөн. Харин 2030 он гэхэд 30 хувьд хүрнэ гэсэн зорилт тавьсан. Мөн дэлхий нийт атомын цахилгаан станцаас татгалзаж эхэлсэн. Дэлхийн дулаарал, хүлэмжийн хийг нэмэгдүүлэхэд ч сэргээгдэх эрчим хүч голлох хүчин зүйл нь болох учиртай. Тэгээд ч нүүрсийг түүхийгээр нь хэрэглэхээс дэлхий дахин татгалзаж эхэлсэн. Энэ бүхнийг бодолцож үзэхэд ч манай улс одооноос дэлхий дахинтай мөр зэрэгцэх хэрэгтэй. Үүнээс улбаалан сэргээгдэх эрчим хүчний хууль гарсан. Маш сайн хууль болсон гэж мэргэжлийн улсууд дүгнэдэг. Тэр утгаараа гадны хөрөнгө оруулалт энэ салбарт идэвхтэй орж ирж байгаа юм болов уу гэж бодож байна.

"Моннаран" төслийн хүрээнд баригдах сэргээгдэх эрчим хүчний станц хэдийд ашиглалтад орох вэ?

-Манай станц хөдөө аж ахуйд суурилсан болохоор жаахан ажиллагаатай. Бид станцаа хоёр үе шаттайгаар ашиглалтад оруулахаар

...Тэгээд ч Засгийн газар эдийн засгийг маш богино хугацаанд сэргээх зүйл бол ашигт малтмал тэр дундаа алтыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал гэж үзсэн. Алтны үнэ цэнэ дэлхийн зах зээл дээр өндөр байсан. Тиймээс гадагшаа урсах урсгалд хориг тавьж, алт олборлолтыг төрийн зүгээс дэмжих хөтөлбөр боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлсэн гэдгээрээ бидний ажил далайцтай болж чадсан...

төлөвлөсөн. Эхнийх нь энэ оны зургаадугаар сард, Тодруулбал, 2,4 МВт-ыг ашиглалтад оруулна. Үүний дараа наймдугаар сард бүтнээр нь 10 МВт чадалтай станцаа ашиглалтад хүлээлгэж өгөх учиртай.

-Үйлдвэрлэсэн эрчим хүчээ хаашаа нийлүүлэх төлөвлөгөөтэй байгаа вэ?

-Бидний хийсэн тооцоогоор Төв аймгийн Баянчандманий дэд станцан нийлүүлэхээр 30км агаарын шугам татсан. Станц бүрэн хүчин чадаараа ашиглалтад орсон тохиолдолд Баянчандмань, Баянцогт, Нөхөрлөл, Атар, Авдрант, Жаргалантыг эрчим хүчээр

хангах юм.

-Хоёулаа ярианыхаа сэдвийг өөрчлөө. Одоо хэрэгжих гэж байгаа "Алт-2" хөтөлбөр ном журмаараа бол "Алт-3" шүү дээ. Энэ нь нэг талаараа өмнөхөө үгүйсгээд байгаа ч юм шиг. Жилийн өмнө "Алт" хөтөлбөрийг боловсруулж явсан хүний хувьд та юу гэж бодож байна вэ?

-Чин үнэнийг хэлэхэд, Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн тэр он жилүүдэд иргэн хүн уул уурхайн компани байгуулан үйл ажиллагаа явуулаад зогсохгүй ашиг олж болдог юм байна гэдгийг мэдрүүлсэн зүйл бол "Алт" хөтөлбөр шүү дээ. Ач холбогдлын тухайд олон зүйлийг хэлж болно. Тухайлбал, "Алт" хөтөлбөр хэрэгжсэнээр хямрайд ороод байсан Монгол Улсын эдийн засгийг сэргээснээс гадна алтны нөөцийг нэмэгдүүлсэн. Бас сайнтай зэрэгцээд сөрөг зүйл ч гарч ирснийг дурдахгүй өнгөрч болохгүй. Хууль бусаар алт олборлогчид байгаль орчныг хэрхэн сүйтгэж орхисныг та бид эдлэх мэдэж байгаа шүү дээ. Байгаль орчны доройтол тэр үеэс эхтэй. Тэр үед хэн бүхний толгойд баяжих хүсэл байснаас биш байгаль орчноо хайрлан хамгаалах, алтны нөөцийг хэрхэн хууль бусаар алт олборлогчид татвараас зугтаагчдаас болж алтны салбар тэр чигээрээ унасан. Түүнийг ил болгох нь бидний нэн тэргүүнд хийх ажил байсан. Тэгээд ч Засгийн газар эдийн засгийг маш богино хугацаанд сэргээх зүйл бол ашигт малтмал тэр дундаа алтыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал гэж үзсэн. Алтны үнэ цэнэ дэлхийн зах зээл дээр өндөр байсан. Тиймээс гадагшаа урсах урсгалд хориг тавьж, алт олборлолтыг төрийн зүгээс дэмжих хөтөлбөр боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлсэн гэдгээрээ бидний ажил далайцтай болж чадсан.

-Урт нэртэй хуулийн хэрэгжилт алт олборлогчид ихээхэн саад болсон гэж салбарынхан нь дүгнэдэг?

-Ерөнхийдөө үзэл санааны хувьд зөв хууль. Харамсалтай нь хуулийн хэрэгжилт хууль

"Алт" хөтөлбөрийг боловсруулах явцад энэ салбарын хууль, эрхзүйн орчныг өөрчлөх шаардлага зайлшгүй тулгарсан уу?

-Гол нь татварын тогтолцоог өөрчлөх ёстой гэж үзсэн. Алтад 10-15 хувийн татвар оногдуулдаг байсныг Монголбанкинд тушаасан тохиолдолд татварын хэмжээг бууруулж, 2.5 хувь болгон өөрчилсөн. Үүний үр дүнд таван тонн гаруйгаар буураад байсан алтны тушаалт 3-4 тонноор нэмэгдсэн шүү.

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам "Алт-2" хөтөлбөрийг боловсруулахдаа та бүхний хийсэн тооцоо, судалгааг үндэслэж байгаа юм билээ. Тэгэхээр та бүхэн "Алт-2" хөтөлбөрийн суурийг тавьсан болж таарах нь?

-Тэгж хэлж болох байх. Анхны "Алт" хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд эн салбарт хөл тавьсан ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхтэй болж, алт олборлох, хайх хөтөлбөр эрчимжсэн байдаг. Гэвч тухайн цаг үеийн эдийн засгийн нөхцөл байдал, хууль бусаар алт олборлогчид, татвараас зугтаагчдаас болж алтны салбар тэр чигээрээ унасан. Түүнийг ил болгох нь бидний нэн тэргүүнд хийх ажил байсан. Тэгээд ч Засгийн газар эдийн засгийг маш богино хугацаанд сэргээх зүйл бол ашигт малтмал тэр дундаа алтыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал гэж үзсэн. Алтны үнэ цэнэ дэлхийн зах зээл дээр өндөр байсан. Тиймээс гадагшаа урсах урсгалд хориг тавьж, алт олборлолтыг төрийн зүгээс дэмжих хөтөлбөр боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлсэн гэдгээрээ бидний ажил далайцтай болж чадсан.

-Урт нэртэй хуулийн хэрэгжилт алт олборлогчид ихээхэн саад болсон гэж салбарынхан нь дүгнэдэг?

-Ерөнхийдөө үзэл санааны хувьд зөв хууль. Харамсалтай нь хуулийн хэрэгжилт хууль

хэрэгжиж эхлэхээс өмнө хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүдэд хүндээр туссан. Хууль боловсруулагчид хуулийн хэрэгжилт гадаадын хөрөнгө оруулагчид ямаар тусахыг бодолцож үзээгүй. Тиймээс цаашид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулийн төсөл боловсруулахдаа нөхцөл байдлыг мэдэрч, үүндээ тохирсон арга хэмжээг авах ёстой. Урт нэртэй хуулийн хэрэгжилтийн тухайд шийдвэрлэж чадахгүй байсан зарим зүйлийг гадаанаас гаргасан ч гадаадын хөрөнгө оруулалт бүхий олон компани хохирсон гэдгийг хэлэх ёстой. Судалгаа хийж байхдаа гадны хөрөнгө оруулалт бүхий компаниудыг яах ёстойг хуулийн төсөлд тусгаагүйн улмаас асуудалд ялгавартай хандсан мэт сэтгэгдлийг нийгэмд төрүүлсэн. Тиймээс яамны зүгээс хөрөнгө оруулалт нь хийгдчихсэн компаниудын үйл ажиллагаанд хатуу хяналтыг тавих байдлаар асуудлыг цэгцэлсэн. Үүний үр дүнд байгаль орчинд хор хохирол учруулж байсан явдлыг хуулийн хүрээнд цэгцэлсэн. Нөгөөтэйгүүр, урт нэртэй хуулийн хэрэгжилт алт олборлолтод нөлөөлж байсныг цэгцэлсэнээр алт олборлолт тодорхой хэмжээгээр нэмэгдэж сэргэж эхэлсэн. "Алт" хөтөлбөр бол олборлолтыг зөв арга зам, зөв чиглэлээр сэргээж, экспортыг дэмжсэн хөтөлбөр болсон.

-Эрдэс баялгийн биржийн асуудал хүчтэй яригдаж байснаа нам жим болсон. Та бүхний хүлээж байсан үр дүн нь юу байсан юм бэ?

-Эрдэс баялгийн бирж байгуулах гэж байсан хэдий ч харамсалтай нь амжаагүй. Тэгээд хөдөө аж ахуйн биржтэй нэгтгэсэн. Уг нь анх тус тусад бирж байгуулах асуудал яригдаж байсан юм. Бидний байгуулах гэж зүтгээд орхисон Эрдэс баялгийн биржийн тухайд үнэхээр их ашигтай хувилбар байсан. Өөрөөр хэлбэл, биржийн үйл ажиллагаа худалдан авагч, олборлогч гэсэн системээр явж, худалдан авагчид шуудаар өрсөлдөн хамгийн өндөр үнийг санал болгосон иргэн, аж ахуйн нэгжид худалдан авах эрхийг олгох байсан юм.

-Яамны зүгээс бичил уурхайчдыг бүртгэлжүүлж, тэдэнтэй хамтрах гарцыг хайж байсан. Үүнийг зөв гэх хэсэг байхад тэднийг өөгшүүллээ хэмээн буруушаах нэгэн ч байсан?

-Хэдэн жилийн өмнө ногоон түмпэн үүрэн уул хадаар алт хайн тэнэхээсээ бүлэг нөхдийг нинжа гэдэг байлаа. Одоо тэднийг тэгж нэрлэх аргагүй болсон. Өөрөөр хэлбэл, нинжа нарын ихэнх нь хэдийнэ хол дээрээ боссон. Зарим нь бүр компанийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй. Тиймээс бүртгэлд хамруулж, үйл ажиллагааг цэгцлэх нь зүй ёсны асуудал. Бүртгэлгүй байхын хэрээр татвараас нуугдаж, гадагшаа гарах алтны урсгалын хэмжээ нэмэгдэнэ. Сүүлийн үед томоохон компаниуд гэрээгээр бичил уурхай эрхлэгчдийг холсөлж ажиллуулдаг болсон байна лээ. Энэ бол байж болох л хувилбар. Хамгийн гол нь үйл ажиллагаа нь зөв байж, зөв технологи ашиглах хэрэгтэй.

Тал нутгийн цахим мэдээлэл

STRESS

Огъом УгАТ

Бри Ларсон:

Орчуулсан Б.ДАВАА

"Оскар"-ын шагналт жүжигчин Бри Ларсоны "The Vogue" сэтгүүлд өгсөн яриллагыг орчуулан хүргэж байна. 27 настай жүжигчин бүсгүй энэ жил "Өрөө" киноны гол дүрээр Шилдэг эмэгтэй гол дүрийн "Оскар" гардсан билээ. Мөн эдүгээ "Тэнгис" кино театрын дэлгэцнээ гарч буй "Kong: Skull Island" кинонд фото сурвалжлагчийн дүр бүтээсэн юм.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 10
Шөнө 5

Нөгөөдөр

Өдөр 9
Шөнө -3

Өдрийн зурхай

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Наран ургах шингэх: 05.22-20.15
Үс засуулбал: Эд мал арвидна



Тухайн өдөр тогой, торь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтай хандаж, биеэ энхрийлүүштэй. Буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амилуулах, дэлгэрүүлэх, эрхнээх үйл нигүүд бүтээхэд сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнээл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загтанал алгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэтцэл болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, тогой, хонь, нохой болой.

Бидэнд тохиолдсон

КВНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД

Reds Zimo

Хамт явсан найз банкинд дугаарлаад. Би койно нь утсаа оролдоод л зогсож байлаа. Тэгсэн чинь нэг өвөө ирээд найзын чихэнд юм шивнэчихээд явлаа. Мань хүн эргэж харснаа инээж энэ тэр. Яасан гэсэн чинь "Ард чинь нэг каяачин царайтай юм өлбөлзөөд байна. Халаасаа мэдээтэй байгаарай" гэж шивнэсэн гэнэ. Би тэгээд бантсандаа гадаа гарч хүлээнгээ машины цонхонд өөрийгөө харангаа бодно. "Би тийм хулгайч харагдаад байгаа юм байх даа. Энэ малгайтай цамц саравчтай малгайнаас л нэг боллоо". Тэгсэн нэг ах машинаасаа бууж явснаа буцаж ирснээ над руу нэг хараад толно хаачихаад явдаг байгаа. Зөө зөө өөр тайван даа.

"Өрөө" киногоороо Оскарын шилдэг гол дүрийн эмэгтэй жүжигчний шагнал хүртсэн. Түүнээс хойш уран бүтээлчийн тань хувьд юу өөрчлөгдөв?

-Орчин гойрны хүмүүсийн намайг харах нүд өөрчлөгдсөн байж магадгүй. Гэхдээ хувь хүн талаас, жүжигчний хувьд өөрчлөгдсөн зүйл байхгүй. Урьдын адил дүрдээ хэрхэн орох вэ гэсэн асуудал тулгарсаар л байна.

Энэ л миний кинонд татагдсан шалтгаан юм даа

Энэ байдал одоо ч, өмнөхөөсөө өөрчлөгдөөгүй. Өөрчлөгдөөгүй нь ч болсон гэж бодож байгаа.

-Энэ удаа "Kong: Skull Island" кинонд тоглох болсон шалтгаан?

-Кинонд өгүүлэх гол санаанд нь татагдсан. Яг "Кинг Конг" шиг баатарлаг адал явдалт кинонд тоглохыг дандаа л хүсдэг байлаа. "Kong: Skull Island" байгаль орчны асуудал, хүний хүчин зүйл, хайр дурлал, хүн төрөлхтөнд юу хамгийн чухал болох, юуг хамгаалах шаардлагатай вэ гэдгийг ухааруулсан бүтээл болсон. Энэ л миний кинонд татагдсан шалтгаан юм даа.

-“Өрөө” кинонд ээжийн дүр, энэ кинонд фото сэтгүүлчийн дүрийг бүтээсэн. Дүрээ бүтээхэд олж авсан хамгийн чухал сургамж нь юу байсан бэ?

-Үнэнээрээ л байх хамгийн чухал юм байна гэдгийг ойлгосон. Энэ удаад тоглосон Мэсон Вэйвер шиг, зөвхөн бодит үнэнийг олон нийтэд хүргэхийн төлөө зургаа тасралтгүй авсаар л байдаг фото сэтгүүлч эмэгтэйчүүд амьдрал дээр маш олон бий. Тиймээс би боломжийнхоо хэрээр фото сэтгүүлчийн ажлыг судалж, тэдгээр бүсгүйчүүд хэрхэн ажиллаж, амьдардаг юм бэ гэдгийг харуулахыг хүссэн. Зураг авалт

эхлэхийн өмнө дүрийнхээ талаар судалгаа хийх шаардлагатай болсон учраас хэдэн сарын хугацаатай амралт авч, судалгааны ажилдаа орсон.

-Австрали, Хавай, Вьетнам гэх мэт дэлхийн өнцөг булан бүрт зураг авсан. Зураг авалтын талбайгаас хамгийн их дурсамж үлдсэн үлдээсэн газрыг нэрлээч?

-Маш олон байгаа. Гэхдээ Австралид маш олон имжний хажууд зураг авсан. Өдөр бүр нар мандах үе буюу 04:00 цагт зураг авалт эхэлж, нар шингэхэд дуусдаг байлаа. Байгалийн үзэсгэлэнд хэдэн өдөр амьдарсан минь дурсамж болон үлдсэн. Өдөр бүр жаргаж буй

нарыг тольдоход сэтгэл үнэхээр их хөдөлдөг юм билээ.

-Та өөрөө ч гэсэн энэ кино шиг адал явдалд дуртай л биз дээ?

-Дуртай. Ялангуяа аялалд явах дуртай. Кино зураг авалт дууссаны дараа байнга хаа нэгтээ аялалаар явдаг юм. "Кинг Конг" киноны зураг авалт дууссаны дараа Австралийн их шүрэн далангаар аялсан. Хадан хясаан дээрээс үсрэн хөгжилдөж, басхүү далайн өөр нэгэн ертөнцөөр үргэлжлүүлэн аялсан шүү.

-Хамгийн дуртай брэндээ нэрлээч гэвэл?

-RODARTE-д дуртай. Тэдний коллекц нь "Зельдагийн домог"-ын тоглоомыг санагдуулам загвартай

байдаг. Гоёмсог, тансаг. Рок од Принстэй адил мэдрэмж төрүүлдэг.

-Аливаа стресс уур бухимдлаа хэрхэн тайлдаг вэ?

-Бясалгах юм уу, эсвэл видео тоглоом тоглодог. Одоо "The Legend of Zelda: Breath of the Wild" тоглоомыг тоглож байгаа.

-Өнөөдөр ч гэсэн биедээ авч яваа юу?

-Харамсалтай нь, өнөөдөр хараахан авчраагүй. Сүйт залуу минь жаахан уйдаж байгаа болохоор миний оронд тоглож байгаа. /инээв/

-Ирээдүйн төлөвлөгөөгөө танилцуулаач?

-Төлөвлөсөн зүйл одоогоор алга байна.

ДУУЛГАХ СОНИН

Их зохиолч Д.Нацагдоржийн хөшөөнд цэцэг өргөлөө

Монгол Улсад Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 92 жилийн ой өчигдөр тохиолоо. Энэ өдөр хүүхдийн байгууллагыг үндэслэгч, их зохиолч Д.Нацагдоржийн хөшөөнд хүндэтгэлийн цэцэг өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагдсан юм. Тус үйл ажиллагаанд УИХ, Засгийн газар, Нийслэлийн удирдлагууд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, Дүүргүүдийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга, мэргэжилтэн ажилтанууд, хүүхдийн байгууллагын үе үеийн ахмадууд, хүүхдийн хөгжил оролцооны байгууллагууд, хүүхдийн төлөөлөл оролцож хүндэтгэл үзүүлэн, "Пионерын дуу" дууллаа. Хүүхдийн байгууллага нь Монгол Улс тусгаар

тогтнолоо олсон цаг мөчийн дараахан буюу 1925 онд санаа зориг нийлсэн хэсэг залуучуудын санаачилгаар "Хойчийг залгамжлагч багачуудын холбоо" нэртэйгээр анх байгуулагдсан түүхтэй юм.Энэхүү холбоо нь шинэ үеийн зохиолч Д.Нацагдоржоор удирдуулж, "Бүхний олон багачууд" дууг эгшиглүүлэн мянга мянган хүүхэд залуучуудын зүрх сэтгэлийн нэгэн зүгт хандуулахад ихэд анхааран ажилладаг байжээ.

Монголын хүүхдийн байгууллага нь,
-1925-1940 онуудад Монголын пионерийн байгууллагын төв товчоо
-1940-1949 онд МХЗ-ийн төв хорооны сургууль-пионерийн байгууллагын төв зөвлөл



-1991 оноос Монголын Хүүхдийн төлөө Үндэсний газар
-2016 оноос Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нэртэйгээр хүүхдийн байгууллага өргөжин тэлсэн түүхтэй.

Монгол морьдын хүрэл баримал ялалтын цэцэрлэгт нээлтээ хийлээ

Аугаа Эх орны дайны Ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан бүтээсэн Монголын ард түмний бэлгийн "Ялалтад тэмүүлсэн морьд" хөшөөний нээлтийн ёслолын арга хэмжээ Москва хотын Хүндэтгэлийн дэнж дэх Ялалтын цэцэрлэгт хүрээлэнд болжээ. Москва дахь Элчин сайдын яамнаас Москва хотын Засгийн газартай хамтран зохион байгуулсан энэхүү хүндэтгэлийн

арга хэмжээнд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа, ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд Г.Б.Карасин, ОХУ-ын Дотоод хэргийн орлогч сайд И.Н.Зубов, нарын албаны хүмүүсээс гадна Москва хотын Засгийн газрын төлөөлөл, ахмад дайчид, ЭСЯ-ны ажилтанууд, Москва хотод

амьдарч, ажиллаж, сурч буй Монгол иргэд, оюутнуудын төлөөлөл оролцсон байна.

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил хөшөөг нээж хэлсэн үгэндээ Зөвлөлтийн ард түмэн хүн төрөлхтний түүхэнд хамгийн их цус урсгасан их дайнд Ялалт байгуулан фашизмын дарлалаас хүн төрөлхтнийг аварсан аугаа түүхтэй гээд Аугаа Эх орны дайны хүнд, хэцүү жилүүдэд Монголын

ард түмэн Зөвлөлт Холбоот Улсад дулаан хувцас, хүнс болон хагас сая агт морьдыг илгээж, Монголын ард түмний хөрөнгөөр бүтээсэн "Хувьсгалт Монгол" танкийн цуваа, "Монгол ард" нисэх онгоцны эскадрилийг Улаан армид хандивлаж, монгол морьд хөлөглөсөн Зөвлөлтийн дайчид Берлин хүрсэн түүхтэйг онцлон тэмдэглэжээ.

УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цуа, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлаат анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танад:

- Ган болон мөнгөн зүү, шалхаглан зүү
- Хануур, сам соруул
- Шарлага
- Бумба төвнө засал
- Халуун чулуу, давсан халуун жин засал
- Эмчилгээний цэгэн барна
- Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн барна зэрэг уламжлаат анагаах ухааны эмчилгээ үйчлэлгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/